

МОНГОЛЫН ТӨР БА МАЛ СҮРЭГ (1921-1959)

З.ЛОНЖИД

Товч агуулга: 1921-1950-иад оны эцэс хүртэлх хугацаанд Монголын төр эдийн засгаа хөгжүүлэх талаар төлөвлөсөн бодлого, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны зарим чиглэлийг тун хураангуйлан энэ өгүүлэлд авч үзлээ. Чингэхдээ урьд өмнө судалгааны эргэлтэд ороогүй сурвалжид тулгуурлан санаа дэвшүүлэх, гаргалгаа хийж, дараа дараагийн судлаачдад өчүүхэн боловч тус дөхөм үзүүлэхийг хичээлээ.

Түлхүүр үг: Мал сүрэг, эдийн засгийн бодлого, татвар, баячууд, зарц, хоршоолол, нэгдэл

Удиртгал

Аль ч улсын төр өмнөх үеэсээ багагүй зүйлийг уламжлан үргэлжлүүлдэг нийтлэг жишигтэй билээ. 1911 онд тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан Монголын төр улс орноо хөгжүүлэхийн тулд олон зүйлд онцгой анхаарч байсны нэг нь эдийн засаг аж ахуйн бодлого байсан юм. Тухайн үед Монголын эдийн засгийн үндсэн салбар нь бэлчээрийн мал аж ахуй байсан учир мал сүргийнхээ тоо толгойг аль болохоор өсгөж улсын төсвийн орлого бүрдүүлэх эх үүсвэр болгохын сацуу уурхайн баялгаа түрээсээр ашиглуулж санхүүгийн хуримтлалтай болохыг хичээж байв. Мөн түүнчлэн төр, шашны байгууллага, ард иргэдийн эрэлт, хэрэгцээтэй хүнсний бус буюу тавилга хэрэглэл жирийн ба гоёлын хувцас хийх бөс даавуу, гэр ахуйн төмөрлөг эдлэлийг зөвхөн импортын бараа бүтээгдэхүүнээр хангаж байв. Гэхдээ өөрийн үйлдвэр аж ахуйн газруудыг хамгийн энгийнээс эхлэн байгуулахыг эрмэлзэж нэлээд зүйл сэдсэн боловч улс төрийн байдлаас шалтгаалан хэрэгжүүлж эхлэх боломж олдоогүй юм. Гэвч өмнөх төрийн энэ эрмэлзлэлийг 1921 оны хавраас эхлэн Монголын төр хэрэгжүүлэх бодлогод эргэлтгүй шилжсэн билээ.

Нэхэн хянавал, хэмжээгүй эрхт Богд эзэн хааны тэргүүлсэн Монгол Улсын төрийн эдийн засгийн бодлогыг Ардын төр 1921-1924 ондуламжлан үргэлжлүүлсэн юм.

1921-1959 онд Монголын төрөөс эдийн засаг, аж ахуйгаа хөгжүүлж хөл дээр нь зогсоохын тулд боловсруулан хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааг хоёр үед хувааж болно. Нэгдүгээрт, 1921-1928 он буюу үндэсний ардчилсан чиг баримжааг тууштай хэрэгжүүлэгч Монголоо, улс үндсээ хэмээсэн Бодоо, Данзан, Амар, Цэрэндорж, Дамбадорж, Жадамба нарын үе. Хоёрдугаарт, 1929 оноос хойших 30

жилийн туршид зөвхөн хар элэгтэй харийнхан буюу улаан оросын зааврыг ёсчлон хэрэгжүүлсэн зүүнтний их хийрхэгчид Шижээ, Лааган, Бадрах болон социализм байгуулна хэмээх сайхан үлгэрт үнэмшсэн гэнэн дарга нарын захиргаадлыг манай ард түмэн туулж өнгөрөөжээ. Зарим мэргэдийн айлдаж байгаагаар бол улирч өнгөрсөн түүхийг шүүмжлэх нь тэнэг хэрэг гэнэ. Гэтэл зарим мэргэд түүхэнд шүүмжлэлтэй эс хандвал юу суралцахаа үл харна гэдэг аж. Бодоход энэ хоёрын аль аль нь буруу бус боловч нэгэнт болж өнгөрсөн түүхийг үнэнээр нь өгүүлэх үүднээс хар цагааныг нь ялгаж салгах нь зүй билээ. Жич: 1929 оноос 1990 он хүртэл манай төрд өндөр алба хашсан бараг бүх хүн улс эх орон ард түмэндээ хар буруу санаж байгаагүй нь мэдээж боловч их гүрний түрэмгий зааврыг илэрхий эсэргүүцэх «эр зориг» дутмаг байсныг хэн хүнгүй мэдэх буй за. 1922 онд Монголын Засгийн Газрын шийдвэрээр томилсон тусгай комиссын гишүүд А.Амар, С.Жамьян, Б.Цэрэндорж, Ц.Дамбадорж, Н.Жадамба, Ж.Цэвээн зэрэг ухаалаг хүмүүс удаан хугацаанд шүүн хэлэлцэж шүүмжлэн зөвлөж боловсруулаад төр засагт өргөн барьсныг 1923 оны зун эрх бүхий байгууллагын хурлаар батлан хэрэгжүүлж эхэлсэн “Эдийн засгийн үндсэн бодлого” хэмээх хөтөлбөрийн шинжтэй удирдамж баримт бичиг юм. 1921-1928 оны үеийн Монголын эдийн засаг, боловсролын аль ч сэдэв асуудлыг судлахад уул баримт орхиж болшгүй тулгуур хэрэглэгдэхүүн болох учир бид түүнийг түлхүү ашиглалаа.

1. Монголын төр мал сүрэг ба албан татварын тухайд

Хэдэн мянган жилийн турш мал адгуулан усны тунгалаг, өвсний соргогийг шилж байнга нүүдэллэн амь зууж ирсэн бидний монголчууд малаа эрдэнэ хэмээн илүү дээдэлж хоньгүй хүн ховдог, морьгүй хүн мохдог хэмээн үеэс үед захисаар бидэнтэй золгожээ.

1921 оны намраас эхлэн Монголын төр мал сүргийн тухайд дам байдлаар холбогдох зарим шийдвэр гаргажээ. Тухайлбал, мал сүргээс татвар хураахдаа баяд, ноёд, ард, хутагт лам хэмээн ялгаварлахгүй нэг адил зарчим баримтлалаа 1921 оны 9-р сарын 14-нд “Уриа” сонинд хэвлүүлэн мэдэгджээ. Дээр өгүүлсэн “Эдийн засгийн үндсэн бодлого”-ын 1-р зүйлд хамгийн ашигтай мал бол “үхэр, хонь, эрхэм болоод адуу дараа нь орно”¹ гэж тодорхойлоод бидний “мал адгуулах нь маш бүдүүлэг” хэмээн санаа зовж буйгаа илэрхийлж мал сүрэг өсөж үржих нь тогтворгүй “цас, шуурга болоод мялзан, дэлүү, чээж, боом, хатайр, хамуу, ям хулгана, чөдөр зэрэг эмгэг ба чоно, усгүй” зэргээс болж жил бүр хэдхэдэн сая тооны мал үхэж хорогдож байгааг тун анхаарах ёстой хэмээн тэмдэглэжээ.

Иймээс ч төр засаг мал сүргийн эрүүл мэндийг хамгаалахад анхаарч уламжлалт ардын эмчилгээний сацуу орчин үеийн мал эмнэлгийн шинжлэх ухааны ололтыг ашиглахыг тун чухалчилжээ. Тухайлбал, 1923 онд Засгийн Газрын

¹ Эдийн засгийн үндсэн бодлого, УБ, 1923. Нэгдүгээр зүйл.

шийдвэрээр Сангийн Яамны дэргэд Мал эмнэлгийн хэлтэс байгуулж мөн оноос эхлэн ЗХУ-аас малын их, бага эмч нарыг урьж удаан хугацаагаар ажиллуулах болсон юм. 1923 онд анх 3 их эмч, 2 бага эмч урьж ирүүлсэн бол 1932 оны эхээр ЗХУ-ын их эмч 32, бага эмч 65 хүн манай хөдөө аймаг, сумдад ажиллаж байв. Мөн 1924 оноос эхлэн мал эмнэлгийн ажилтан бэлтгэх түр курс нээж хожим нь түүнийг байнгын сургууль болгож 1928 онд анхны 28 бага эмчийг төгсгөсөн нь мал эмнэлгийн үндэсний мэргэжилтний анхных болжээ.

Түүнээс хойш дотоодба гадаадамалын их бага эмч нарыг тогтмол бэлтгэх болсноор мал эмнэлгийн салбарын тоо ч байнга нэмэгдэх бололцоотой болов.

Хэрэв 1924 онд мал эмнэлгийн газар дөнгөж 4 байсан бол 1931 онд 39 болж², 100 гаруй их, бага эмч, ажилтан тэдгээрт ажиллаж байлаа. Ийнхүү 1931 он хүртэлх үед монголын мал сүргийн эрүүл мэндийг сахин хамгаалах бодитой нөхцөл бүрдэж үр дүнгээ өгч байсны үрээр мал сүргийн тоо толгой тогтвортой өсч байлаа.

1921-1940-өөд оны эх хүртэл улсын төсвийн дийлэнх хувь нь мал аж ахуйн татвараас бүрдэж байв. Малын татвар хураахдаа гол төлөв хөрөнгө чинээг нь харгалзан ногдуулж байлаа. Тухайлбал, 1921 онд анх мал аж ахуйтнаас хураах татварын түр дүрэм тогтоон мөрдөж байгаад 1922 оноос эхэлж 1924 он хүртэл ардын аж ахуйтнаас татвар хураахдаа 10 бод хүртэлх малтай өрхийг татвараас чөлөөлж түүнээс дээш тооны малтай бүр өрхийг 10-14, 15-100, 101-200, 201-300 түүнээс дээш бодтой хэмээн ангилж 10-14 бодтой өрхөөс жилд 5 лан, бусад ангийн өрхийн мал тутамд 1-ээс 1 лан 4 цэн мөнгөний татвар хурааж байв.³ Гэвч тухайн үед боловсон хүчин дутагдалтай, данс тооцоо цэгцрээгүй цэвэр мөнгө ховор байсантай уялдаж мал аж ахуйтнаас хураах татварыг бүрэн цуглуулж чадахгүй байлаа.

Нөгөө талаар аж ахуйтныг малынх нь тоогоор хэд хэдэн анги болгож татвар хурааж байсан нь өнгөц ажиглахад адил тэгш мэт боловч малын тоо нь адил байхад ам бүлийн тоо нь өөр өөр ба малчид говь, хээр, хангайд болон зах зээлд ойр хол гэх мэтээр харилцан адилгүй нутаглаж байсан учраас ардын засгийн эхэн үеийн мал аж ахуйн татвар нийт аж ахуйтанд адил хэмжээтэй ногдож хараахан чадахгүй байлаа. Ер нь мал сүргээс хураах татвар 1921 оноос хойш олон жилийн турш жинхэнэ тэгш байж чадаагүй юм. Гэхдээ төр засаг мал сүрэгт ногдуулах татварын хэмжээг ойр ойрхон өөрчлөж байлаа.

Жишээ нь, 1924-1925 онд мал бүхий өрхөөс хураах татварын хэмжээ нь өмнөхөөсөө арай өөрчлөгдөж ядуу аж ахуйтнаас аль болохоор бага, харин чинээлэг, баян өрхөөс нилээд түлхүүхэн авах бодлого баримталж байв. Энэ хугацаанд хурааж байсан татварын хэмжээг авч үзвэл 100 хүртэлх бодтой өрхөөс зөвхөн үндсэн

² НТА (Үндэсний төв архивын МАН-ын баримтын төв), Ф-4, Д-24, ХИ-184, 84.

³ НТА. Ф-1, Д-2, ХН-13, 13; Ф-4, Д-1, ХН-124, 3, 13.

ногдол татварыг, 100-500 бодтойгоос нь үндсэн ногдлын 5%, 501-1000 бодтойгоос нь 10%, 1000-с дээш бодтойгоос 15% өсгөн хурааж байгаад⁴, 1926 оноос Улсын нэгдсэн албан татварын хуулийг шинээр боловсруулан батлажээ. Уг хуулийн заалтаас үзвэл 2 хүртэл бодтой өрхийг албан татвараас бүрмөсөн хэлтрүүлж 6-10 бодтой бөгөөд ам 4-өөс дээш ам бүлтэй өрхийн 3 бодыг, 11-20 бодтой өрхийг ам бүл харгалзахгүйгээр 2 бодыг тус тус албан татвараас чөлөөлж 21-50 бодтой өрхөөс үндсэн ногдлыг хурааж, 51-100 бодтойд үндсэн ногдлыг 3%, 101-500 бодтойгоос 15%, 501-550 бодтойгоос 30%-иар нэмж өсгөсөөр дээд тал нь үндсэн татварыг 120% хүртэл нэмж хурааж байлаа⁵. Энэхүү дүрэм нь ядуу дунд аж ахуйтныг тэтгэж байсан боловч баян чинээлэг аж ахуйтныг аль болохоор хавчин хязгаарлахад чиглэсэн учраас аж ахуйтны дээд ангилалд багтах олон малтай айл өрхийн тоо огцомхон цөөрч эхэлжээ. Жишээлбэл: 1927 оны эцэст 500-гаас дээш бодтой өрхийн тоо 1924 оныхоос 1.9 дахин цөөрсөн байдаг.⁶ Энэ нь төр засгаас ардын аж ахуйтныг дунджуулах бодлого хэрэгжүүлж байсны дагуу боловсруулсан татварын заалттай шууд холбоотой. Гэвч олон малтай өрх аж ахуйтан эрс цөөрч байхад гар хоосон ба ядуу аж ахуйтны тоо төдий л хорогдохгүй байлаа. Жишээ нь 1924 онд 2-20 бодтой өрх нийт аж ахуйтны 25%-ийг эзэлж байсан бол 1928 онд 35% болж⁷ олширсон байна. Үүнээс үзэхэд аж ахуйтныг дундажлах бодлого зөв үр дүн үзүүлсэнгүй. Харин ч сөрөг нөлөөлсөн байна.

Мал аж ахуйн алба татвараар мал сүргийн өсөлтийг нэмэгдүүлж, мал аж ахуйтны хөрөнгө чинээний туйлшралыг зохистой тогтворжуулж чадаагүй учир 1928 оноос дахин татварын бодлогыг өөрчилсөн байна. Шинэ хуулийн гол агуулга нь ядуу аж ахуйтныг тэтгэхэд чиглэжээ. Хэрэв 1926-1927 онд 6-10 бодтой өрхөөс дунджаар 3 бодыг татвар чөлөөлж байсан бол 1928 оны өөрчлөлтөөр дээрх тооны малтай өрхөөс 5 бод чөлөөлж 11-15 бодтойгоос 2 бод чөлөөлж байсныг 4 болгож 16-20 бодтойгоос 2 байсныг 3 болгож, 21-25 бодтой өрхөөс 2 бод 26-30 бодтой өрхөөс 1 бодын ногдол чөлөөлж 31-70 бодтой өрхөөс татварын үндсэн ногдлыг түүнээс дээшхээс нь 100% (малын үнийн 30 төгрөг, үл хөдлөх хөрөнгийн 90 төгрөгийг тус тус нэг хувьд бодно) тутамд нэг хувь өсгөн нэмэгдүүлж хураахаар тогтсон байна. Татвар хураах ногдлын хэмжээг 1926 оны малын тоогоор гаргаж байсан учраас 2 жилийн хугацаанд хэдэн мал өссөн хорогдсоныг харгалзаагүйгээс болж зарим талаар бодитой ногдол болж чадаагүй юм. Ернэ 1927-1929 онд ч аж ахуйтнууд хөрөнгө чинээний бүлэглэлийн бүтэцэд нилээд өөрчлөлт үргэлжлэн гарсан нь Коминтерний заалтаар нийт өрх хүн амыг хөрөнгийн хувьд жигдрүүлж дундчууд болгох бодлого хэрэгжүүлж байсантай шууд холбоотой. Тэгэхдээ огт малгүй ба бод хүрэхгүй цөөн малтай өрхийн тоо дурдсан хугацаанд төдийлөн

⁴ БНМАУ-ын анхдугаар их хурал, Эмхтгэл, УБ, 1984.

⁵ БНМАУ-ын Засгийн газрын албан сэтгүүл, 1927 №20, 15-20.

⁶ Хозяйство, 1929 №4, 20.

⁷ НТА. Ф-1, ХН-52.

3. Лонжид

буурсангүй харин ч 1.2%-иар өсчээ. Гагцхүү 200-аас дээш бодтой өрхийн эзлэх хувь 0.6%-иар цөөрсөн байна. Үүнийг доорх хүснэгтээс тодорхой харж болно.

Хүснэгт 1.1927-1929 онд мал бүхий аж ахуйтны бүтцэд гарсан өөрчлөлт

Он	1927	1928	1929
Аж ахуйтны бүлэглэл	Нийт өрхийн хэдэн хувь		
1. Огт малгүй ба бод үл хүрэх малтай	3.4	2.3	4.6
2. 1-10 бодтой	35.3	38.3	35.7
3. 11-20 бодтой	20.3	19.3	23.4
4. 21-100 бодтой	34.3	34.8	31.1
5. 101-200 бодтой	4.5	4.3	3.5
6. 201 -ээс дээш бодтой	2.3	1.1	1.7
Дүн	100.0	100.0	100.0

Дээрх хүснэгтээс үзэхэд 201-ээс дээш малтай өрх 1927 онд 3168 болж нийт өрхийн 2.3%-ийг улсын нийт малын (бодод шилжүүлснээр) 247.9%-ийг эзэлж байсан бол 1928 онд өрхийн тоо 1787 болж нийт өрхийн 101% бүх малын 14.4%-ийг эзлэж байлаа.

Энэ нь чинээлэг, баян айл өрхийн тоо, тэдний өмчинд байсан малыг цөөрүүлснээр мал аж ахуйтны ядуу хэсгийн аж байдлын түвшинг дээшлүүлж болдоггүйг тодорхой үзүүлжээ. Өөрөөр хэлбэл ядуу хэсэг нь олон малтай айл өрхийн малыг хариулж гэдсээ тэжээхээс гадна тэднээс ажлынхаа хөлсөнд авсан малаар амь зуулгын хэдэн малаа нөхөн сэлбэдэг байсан нь тодорхой харагдаж байна.

1924-1929 онд буюу зүүнтний үйл ажиллагаа эрчимжихээс өмнөх үед Монголын мал сүргийн нийт тоо толгой ихээхэн эрчимтэй өсөж 1924 онд 13.7 сая мал байсан нь 1929 онд 21.9 сая толгойд хүрч⁸, 59.89-иар буюу 8.2 саяар өссөн байна. Гэвч энэ үзүүлэлтийг сайтар нягтлах аваас цэвэр өсөлт хараахан бус юм. Тодруулбал 1924 оны үеийн мал тоологонд ардын бүх малыг хамруулж огтхон ч чадаагүйд эргэлзэх явдалгүй ээ. Олны дунд түгээмэл тархсан яриагаар бол баг, сум, хошуу, аймаг тус бүрдээ малын тоог дарж аль болохоор бага алба үзэхийг хичээдэг байсан гэдэг. 1924 оноос эхлэн малын тоо толгой дарагдуулагчдад хуулийн хариуцлага хүлээлгэх болсон учир хөдөөгийнхөн буюу малтай иргэд сүргийнхээ тоог тийм ч их дарж чадсангүй бололтой. Өөрөөр хэлбэл малын тооллого бодит байдалд нилээд ойртжээ.

2. Зүүнтэний хийрхэл ба хөрөнгө, мал хураасан чухам учир

1928 оны эцсээр Коминтерний Гүйцэтгэх Хороо Б.Шмераль тэргүүтэй тусгай комиссыг Монголдирүүлж МАХН-д гарсан баруун оппортунизмын аюулыг

⁸ БНМАУ-ын Хөдөө аж ахуй 50 жилд, Статистийн эмхтгэл I-р хэсэг, 1974, 50.

илчлэж намын бодлогыг зөв шугамд нь оруулах “*их ажил*” зохион байгуулж намын VII Их Хурлыг хуралдуулжээ. Тэрхүү хурлаас гаргасан шийдвэр нь Монголын тухайн үеийн бодит байдалд огтхон ч нийцэхгүй байсан брловч хүчээр хэрэгжүүлж эхэлсэн юм. Тэр үеийн буруу шийдвэрийг түүхчид зүүнтний нугалаа хэмээн нэрлэсэн бөгөөд 1928 оны эцсээс 1932 оны дунд үе хүртэл үргэлжилсэн зүүнтний бодлого тус улсын нийгэм, эдийн засгийн амьдралд ялангуяа мал сүргийн тоо толгойн өсөлтөд ихээхэн сүйрэл учруулсан билээ.

Тухайлбал, МАХН-ын VII их хурал албан татварын бодлогын талаар хийсэн дүгнэлтдээ: албан татвар нь “ерөнхийдөө хуучин үеэс хөнгөдсөн боловч ядуу ангийн этгээдэд асар хөнгөрөөгүйн гадна хөрөнгөжигсдийг хязгаарлах зэвсэг болон эс чаджээ”⁹ гэж тэмдэглээд цаашид албан татварын бодлогыг шинэ зарчмаар зохиохыг чухалчлан заав. Энэ дагууд 1929 оны дундуур “Ардын өв ба жавын хөрөнгө малаас хураах албан татварыг нэгтгэн явуулах тухай түр дүрэм” батлав. Уг дүрмээр мал тус бүрийг нас хүйсээр нь хэрхэн үнэлэхийг тодорхойлон заажээ. Түүнээс үзвэл тэмээг дунджаар 80 төгрөг, адууг 26 төгрөг, үхрийг 32 төгрөг, хонийг 5 төгрөг, ямааг 3 төгрөг цаа гөрөөсийг 7 төгрөг, илжгийг 7 төгрөг, \ луусыг 30 төгрөгөөр үнэлжээ. 20-иос доош хувьтай өрхийг татвараас хэлтрүүлж, 21-ээс дээш хувь хөрөнгөтэй өрхийг 26 групп болгон 21-50 хувьтай өрхийн ногдол татварыг 1-18 хувиар хөнгөтгөн, 51-200 хувьтай өрхөөс татварыг ямар нэгэн нэмэгдэл ба хөнгөлөлтгүй хурааж, 201-5000 хувьтай өрхийн татварыг 10-320 хувиар, 5001-ээс дээш бол 335 хувиар тус тус нэмэгдүүлэн хураахаар заав.

Нэг жилийн дараагаар энэхүү түр дүрэмд зарим нэмэлт оруулж 1930, 1931 онд дагаж шийтгүүлэхдээ урьд нь дунд аж ахуйтанд үзүүлж байсан хөнгөлөлтийг хэвээр тогтоож харин 100-гаас дээш хувьтай өрхийг нударган хэмээн үзэж ногдол татварыг 100 хувь нэмэгдүүлэн хураах болжээ. Ийнхүү чинээлэг аж ахуйтныг нийтэд нь албан татварын дарамтаар нэрвэх болсны уршгаар 1932 оны зун тус улсын мал 16.2 сая болж 1930 оныхоос 31.3 хувиар хорогдож ардолны амьжиргаа доройтож төрийн сан хоосорч эдийн засгийн хямрал гүнзгийрсэн байна.

Жич, зүүнтний үед манай улсын эдийн засгийн үндэс болсон мал сүрэг үнэхээр 30 гаруй хувиар хорогдсон уу эсвэл арай ч хэтрүүлсэн тоо юм уу гэдэгт эргэлзмээр байдгийг анхаарууштай.

1924-1929 онд мал сүрэг нийтдүнгээрээ өссөн боловч хөдөөгийн ядуу өрхийн тоо нэмэгдэж байсныг бид дээр өгүүлсэн бөгөөд гар хоосон, цөөн малтай ядуу айл өрхийг улсаас зориуд зардал төсөв гаргаад тэжээж асрах эдийн засаг санхүүгийн бололцоо байгаагүй тэр үед төр засаг намын удирдлагынхан цөмөөрөө хэрхэхээ төдий л ойлгохгүй байсан бололтой. Тэдний зарим нь хөдөөгийн амьжиргаа дорой айл өрхийг баян чинээлэг аж ахуйтанд зарцуулан аж төрүүлэхийг гол арга

⁹ МАХН-ын VII их хурал: *Баримт бичиг*, УБ, 1984, 405.

болгон сэтгэж 1925 онд батлан мөрдүүлсэн хүчин үнэлэгчдийн хуулийн дагуу зарц, баян хоёр харилцан тохирч нэг нь нөгөөдөө тус дэм үзүүлэх бололцоотой байсан юм. Гэвч хүн хүндээ зарцлагдах нь нийгэм журам, ардын ёст зарчимд үл нийлэлцэх зохисгүй зүйл хэмээн Коминтерн, ЗХУ-ын удирдлага үзэж Монголын эдийн засагт тухайлбал, өмчийн харьяалалд зарим өөрчлөлт хийж хоёр томоохон зорилт шийдвэрлэж болно хэмээн төсөөлж байв.

Энэ нь юуны өмнө улс төрийн эрхээ алдсан боловч эдийн засгийн хувьд нөлөөтэй хэвээр байсан өмнөх засаглалын үеийн мяндаг тушаалтай лам, хувраг, хутагт хувилгаад, язгуур угсаатан, хад ноёд, түшмэд агчдын нөлөөг бууруулах, хоёрдугаарт хүн амын аж байдал дорой хэсгийг амь зуух өмчтэй болгох бололцоотой хэмээн үзэж тэрхүү язгуур угсаатан мяндаг бүхий лам, хаад ноёд, түшмэдагчдын болон жасын хөрөнгө хураахыг 1927 оноос эхэлж МАХН-ын Төв Хороонд санал болгож байлаа. Гэвч улс төрийн бодлого, үйл явдалдалсын хараатай ухаалаг ханддаг Б.Цэрэндорж, А.Амар, Ж.Цэвээн, Ц.Дамбадорж, Н.Жадамба нар тэрхүү саналыг эсэргүүцэж байв. Ялангуяа жасын малыг огтхон ч хурааж болохгүй гэдгийг тэд Коминтерний удирдлагад тайлбарлаад 1926 онд жас жавын хөрөнгө малаас албан татвар хураахад ихээхэн эсэргүүцэл тэмцэл Хан Хэнтий уулын аймгийн Баянтүмэн хан уулын хошуунд гарч байсан ба бусад хошуунд ч хүрээ хийдийн татвар төлөхөөс дургүйцсэн тохиолдол цөөнгүй гарч байсныг ойлгуулсан юм. Түүний үрээр жасын малыг ядуу ардад гэрээгээр хариулгах болж харин урьдын зэрэг хэргэм, угсаа сурвалжтай иргэд, мяндаг тушаалтай лам, хутагт хувилгаадын хөрөнгийг 1929 оноос эхлэн хураахаас огтхон ч цааргалж болохгүйг Коминтерн тулган шаардсан юм. Үүнээс өмнө ч нас барсан зарим язгууртны хөрөнгийг хурааж байлаа.

Тухайлбал, 1924 онд МАХН-ын III их хурлын төлөөлөгчид Гэлэгдоржийн саналаар Сайн ноён хан Т.Намнансүрэн агсны мал хөрөнгийг, 1925 онд МАХН-ын IV их хурлын заалтаар богд Жавзандамба агсны хөрөнгийг улсын өмчид тус тус шилжүүлжээ. Гэвч улсын санд шилжүүлсэн тэрхүү хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, үр ашгийг нь тооцох талаар ямар ч санаачлага гаргаж ажил зохиогоогүйгээс болж үлэмжхэн хөрөнгө талаар үрэгдсэн буюу хувь хүмүүсийн олз ашиг болон өнгөрсөн билээ. Гэтэл төр намын удирдлагад ажиллагчдын олонх нь өмнөх сургамжаа огтхон ч хайхраагүйгээр үл барам улам олон хүний хөрөнгө хогшлыг хураах ажилд шилжин орсон юм. 1928, 1929 онд хуралдсан МАХН-ын VII, улсын V их хурлын шийдвэрийн дагуу хуучны язгуур угсаатан ноёд түшмэдийн хөрөнгө хураахаар 1929 оны 9 дүгээр сард МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Бага Хурлын тэргүүлэгчид Засгийн Газрын хамтарсан хурлаас шийдвэрлэж тогтоол гаргажээ. Энэхүү шийдвэрийг Монголын нам төрийн удирдах зарим ажилтан урьд нь эсэргүүцэж байсныг сонсож мэдсэн ЗХУ-ын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын ажилтан А.Я.Охтин, Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн банкны

дарга Фисюк нар хамтран А.Амар, С.Довчин нарт мэдэгдэхдээ МАХН-ын Төв Хороо “Феодалын” хөрөнгө хураахдаа олон түмний дороос гарсан саналд тулгуурлахгүйгээр зөвхөн Амуга нарын саналыг дэмжиж дээрээс захиргаадан тушааж шийдвэрлэх гэж байна. Тус улсын дотоод гадаад байдал нааштай бус байгаа өнөөгийн нөхцөлд ингэж хөрөнгө хураах нь нилээд бэрхшээлтэй байдал бий болгох төдийгүй улс орны эдийн засагт үлэмжхэн гарз хохирол учруулж ядуу дунд ардыг дайсагнагч этгээдийг дэмжихэд хүргэж болзошгүй гэж байв.¹⁰ Энэ санал бол Ц.Дамбадорж, Н.Жадамба, Н.Хаянхярваа, Г.Гэлэгсэнгэ, Ж.Цэвээн, А.Амар нар 1928 он хүртэл тууштай баримталж байсан үзэл бодолтой нийцэж байлаа. Гэвч нэгэнт гаргасан шийдвэрийн дагуу хөрөнгө хураах ажил эхэлсэн байв. Дээрх шийдвэрт зааснаар гар хоосон ба таваас доош бодын хөрөнгөтэй айл өрх болон амьжиргаа доройтой хүмүүст хураасан хөрөнгөнөөс хувь олгож тэднийг сайн дурын үндсэн дээр хамтын аж ахуйд эвлэлдэн нэгдүүлэх ёстой байв. Хөрөнгө хураах төв комиссыг БНМАУ-ын Бага Хурлын тэргүүлэгчдийн дарга Х.Чойбалсангаар удирдуулжээ. Хөрөнгө хураахдаа тухайн өрхийн ам бүлийн тоог харгалзахгүйгээр 100 хувийн хөрөнгө үлдээж бусдыг нь хураана. Хэрэв хөрөнгөө нууж дарах, үрэн таран хийхийг оролдвол 10 хувийн хөрөнгө үлдээх ба хөрөнгөө хаацайлах, зарж үрэхийг завдсан хүнийг илрүүлбэл түүнд урамшил шагнал өгөхөөр олонд зарлан сонгохоор тэрхүү тогтоолд заасан байна. Хөрөнгө хураах салбар комиссыг аймаг, хошуудад байгуулж тэдгээрийг удирдаж байх Намын Төв Хороо, Засгийн Газрын төлөөлөгчдийг орон нутагт илгээжээ.

Хөрөнгө хураах ажил мөн оны 9 дүгээр сарын эцсээс эхлэж 1932 оны эх хүртэл үргэлжилсэн бөгөөд 1929-1930 онд 427 түшмэл, хад ноёд агчид, 302 лам, хутагт хувилгаадын, 1931-1932 онд 205 лам хувраг, удган зайран ба 622 түшмэл агчдын хөрөнгө малыг хураажээ. Нийт дүнгээрээ 1924-1932 онд 1054 хад ноёд, язгууртан түшмэл, 507 лам, бөөгөөс буюу 1561 өрхөөс 10 сая орчим төгрөгийн мал хөрөнгө хураажээ.¹¹ Жич тэмдэглэхэд, 1990 оноос өмнө хэвлэгдсэн Монгол улсын түүхийн сурах бичиг, эрдэмтдийн судалгааны бүтээлд хөрөнгөө хураалгасан айл өрхийн тоог 1100 гаруй хэмээн бичсээр ирсэн юм. Гэвч БНМАУ-ын XXI Бага Хуралд Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн дарга Д.Догсомын тавьсан илтгэлд дурдсан тоог зөв хэмээн үзэж дээр дурдлаа.

Хураасан хөрөнгөөс ядуучууд, гар хоосон өрх, гачигдал зовлон тохиолдсон зарим хүнд 2 сая орчим төгрөгийн үнэ бүхий мал, эд хөрөнгө олгожээ. Архивт байгаа сурвалж баримтаас үзвэл зөвхөн 1929-1930 онд хураасан хөрөнгөнөөс 1.7 сая төгрөгийн мал эд хогшлыг амьжиргаа дорой айл өрхөд хуваан олгожээ. Харин 1931, 1932 онд хураасан хөрөнгөнөөс 300-400 мянган төгрөгийн зүйлийг хөдөөгийн ядууст олгосныг данслан бичсэн нэгэн тэмдэглэлд бий. Гэхдээ шинэ тутам

¹⁰ НТА, Ц.1-1-64, тал 1.

¹¹ БНМАУ-ын 21-р бага хурлын илтгэл тогтоол, УБ, 1934, 58.

байгуулсан Газар Тариалангийн аймаг, Өмнөговь аймаг, өөр хэд хэдэн аймгийн 30 гаруй сумын мэдээ ирээгүй байгааг 1932 оны 3 дугаар сард тэмдэглэжээ. Харин хөрөнгө хураасан, түүнийг хуваарилсан эцсийн дүн мэдээг 1932 оны 5 дугаар сард МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга З.Шижээ, П.Гэндэн нарыг Коминтерний Монголын комисс, БХЭ(б)Н-ын Төв Хорооны Монголын секторт танилцуулахаар илгээх тухай МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдийн хурал шийдвэрлэжээ. Ийм учраас энэ талын бүрэн мэдээ ОХУ-ын аль нэгэн архивт байж болох талтай. Түүнийг олж судлавал хураасан, хуваарилсан хөрөнгийн тухай тодорхой зүйл хэлж болох бизээ.

Нам төр, засгийн газрын удирдлагын хамтарсан хурлаас хөрөнгө хураах тухай шийдвэрт зааснаар бол гар хоосон ядуу ба таваас доош бодтой өрхөд хураагдмал хөрөнгөнөөс олгох ёстой байв. Хэрэв 1929 онд нэг хүртэл бодтой өрх 7839 байсан, 1-5 бодтой өрх 25235¹² байснаар бодоход тэр үед 5 хүрэхгүй бодтой өрх лав 17 мянга гаруй болсон бололтой бөгөөд тэдэнд хураасан хөрөнгөнөөс олгосон бол нэг өрхөд дунджаар 110 орчим төгрөгийн мал хөрөнгө ногдож байна. Мөн хураасан хөрөнгийн нэг хэсгийг ядуу, дундаж ахуйтны байгуулсан 130 гаруй хамтрал, артель, нөхөрлөл, коммунд шилжүүлсэн байна.

Улсын сан хөрөнгө бүрдүүлэхэд шууд ба шууд бусаар ихээхэн үүрэг гүйцэтгэж байсан 1500 гаруй өрхийн үлэмжхэн хөрөнгө малыг хурааж аваад улсын бүх хүн амын 3 орчим хувьд буюу үйлдвэрлэл явуулах ямар ч дадлагагүй шахам хамтын аж ахуйд хувааж өгсөн нь улс орны эдийн засагт огтхон ч тус болоогүй, харин ч сөрөг нөлөөлөл үүсгэх эхлэл тавьсан гэж үзэх үндэс бий. Яагаад гэвэл хэдэн үеэрээ дамжин хурааж хуримтлуулсан хөрөнгөө улаан мөнгөний үнэгүй хураалгачихаад харгис феодал, сорогч хувалз хэмээн нэр алдраа гутаалгаж төр засгийн хэрэгт оролцох эрхээ хүртэл хасуулсан 1560 гаруй өрх, тэдний гэр бүлийнхэн ойролцоогоор 6000 гаруй хүн, ялангуяа өмч хөрөнгөнөөсөө хагацсан олон зуун лам хуврагийн шавь нар, хүрээ хийдэд данстай 80 шахам мянган ламын зохих хувь нь нам төрийн шийдвэрт эгдүүцэн дургүйцэж байв. Тиймээс ч 1929 оны намраас эхлээд нам, засгийн бодлогыг ялангуяа хөрөнгө хураахыг янз янзаар эсэргүүцэж байлаа. Гэвч түүнийг үл тоомсорлож МАХН-ын VIII, Улсын VI их хурлаас хөрөнгө хураах ажлыг улам гүнзгийрүүлэх заалт өгчээ. Нэгэнт эхэлсэн олны дургүйцлийг хүчээр намжаах гэж оролдсон боловч гүнзгийрсээр 1932 оны хавар Монголын хэд хэдэн аймагт, хүн амын янз бүрийн бүлэг, албан тушаалтныг хамарсан зэвсэгт бослого буюу бэсрэг дайн эхэлсэн билээ. Хөрөнгө хураах шийдвэр гарсан чухам учир угтаа Коминтерн, ЗХУ-ын удирдлагаас өгсөн заавар зөвлөлгөөтэй холбоотой нь маргаангүй билээ. Гэтэл яг хэрэгжүүлэх үед нь бүр хэтрүүлж язгуур угсаагүй, урьд засгийн үед ямар ч албан тушаал хүлээж байгаагүй боловч өв залгамжилж буюу өөрийнхөө хүч хөдөлмөрөөр хуримтлуулсан

¹² Нам засгаас хөдөө аж ахуйн талаар явуулсан бодлого, УБ, 1958, 166.

чинээлэг баян айл өрхийн хөрөнгийг хурааж янзбүрийн шалтгаанаар ядуу хоосон, амьжиргаа муутай болсон хүмүүст түгээж өгсөн ба тэдний олонх нь авсан малаа өсгөж үржүүлэхээсээ сорчлон төхөөрч идэх нь давамгайлж байлаа.

Шинэ тутам байгуулсан хамтралын гишүүдийн олонх нь хураагдсан хөрөнгөнөөс хүртсэн хувиа нийгэмчлэн хамтын аж ахуйд нэгдэгдээсэн бөгөөд 1929-1931 онд хамтрал, коммун, артель 712-ыг байгуулжээ. Түүнд элсэгчдийн 72% нь ядуу, 28% нь дунд аж ахуйтан байсны гадна 1931 оны 11-р сарын нэгний байдлаар улсын бүх өрхийн 32.2 %, ядуу өрхийн 17.8% бүх мал сүргийн 19.1% хамтын аж ахуйн мэдэлд шилжээд байлаа.¹³ Хамтын аж ахуйн бүх малын 60.3% нь жас ба хөрөнгөө хураалгасан язгууртан, хаад ноёд, түшмэдийн сүрэг, 40 хүрэхгүй хувь нь хамтын аж ахуйд элсэгчдийн нийгэмчилсэн мал байжээ.¹⁴ Шинэ тутам байгуулсан хамтрал коммуныхан үйлдвэрлэл эрхэлж орлого олохоосоо урьд хураагдсан хөрөнгийг дуудлагаар үнэ хаялцуулан борлуулах үед өөрсдийн шохоорхсон хурдан жороо морь, цагаан ганс хөөрөг, алт мөнгө, шүр сувднаас хамаг малаа зарж үрээд хөрөнгөө дуусахад хүрч тэвдэхдээ банкнаас ихээхэн зээл авч түүнийгээ төлж чадахгүй дампуурч байлаа. Уг нь хамтын аж ахуй байгуулах сайн дурын санаачлага эхлэл 1927 оны эцэс, 1928 оны эхээр зарим орон нутагт гарч байлаа. Жишээ нь 1927 оны сүүлчээр Богдхан уулын аймгийн Их Түшиг уулын хошууны Л.Сумьяа нарын 20 гаруй хүн сайн дурын үндсэн дээр энгийн нөхөрлөл байгуулж тариалангаас багагүй ашиг олж байлаа. Гэтэл зүүнтний үед албадан байгуулсан хамтын аж ахуй нь цөөн хэдэн хүмүүст ихээхэн хөрөнгө завшуулж улсын эдийн засагт үлэмж хохирол учруулж олныг бухимдуулж байсан бөгөөд түүнийг шинэ эргэлтийн бодлогоор засаж залруулсан билээ. Тэр үед жас жавын өмчийг шууд хураахгүйгээр улсын ба ядуу аж ахуйтны мэдэлд шилжүүлэх замаар шашны нөлөөг багасгах буюу устгах оролдлого хийсэн юм

3.Төр засаг, жасын мал

XVI зууны үеэс Монголд эхэлсэн хүрээ хийдийн аж ахуй-жас жав бол нэг талаар санваартны дундын өмч, нөгөө талаар улсын сан хөмрөг өсөж арвижихад зохих нөлөөтэй учир ямагт төрийн дэмжлэг хүлээсээр ирсэн өвөрмөц хэлбэрийн өмч байлаа. Жас жавын өмчийн уламжлалыг гэнэт алдагдуулан, түүнд татвар ногдуулах, аж ахуйгаа эрхлэхэд нь төр засаг хөндлөнгөөс оролцохыг 1921 онд шинэ төрийн удирдах ажилтан зарим хүн санаачлаж байсан ба шашны хурал номын зардлыг ногдуулан авахыг хориглож шүтэх бишрэх нь хувийн хэрэг гэж төр засгийн шийдвэрт заасан юм.

Төр, шашны хос ёсоо дээдлэж нэгэн зорилгод эвсэн нэгдсэн сум, хамжлага, шавь тайж, хаад ноёд, лам хувраг хэн боловч шашнаа цэвэр ариун мандуулж

¹³ НТА, Ц.1-1-13, 1-2, 55.

¹⁴ Мөн дээрх, 8-9.

түүний дэг ёсыг хэвээр нь үргэлжлүүлэхийн төлөө үзэл бодол адил байсан учраас хувьсгалын дараах хэдэн жилд төрөөс шашны хэрэгт хэтэрхий хутгалдахаасаа болгоомжилж байсан бөгөөд 1924 оны 5 дугаар сард Монголын төр, шашны тэргүүн нас нөгчиж засаглалын шинэ хэлбэр тогтоосон бөгөөд Монгол улсын харьяат хэн боловч шүтэх бишрэх бүрэн эрхтэйг тус улсын анхны Үндсэн хуульд тунхаглан заасан билээ. Гэвч тэрхүү хуулийн зарим заалтаар хүрээ хийдэд үргэлж суудаг хуврагууд ба урьдын мяндаг тушаалтай хутагт хувилгаадын улс төрийн эрхийг хассан юм. Энэ бол төр засгаас шашны талаар баримтлах бодлогод гарсан томоохон алдаа төдийгүй яваандаа гүнзгийрсээр нийгмийн хямралт байдал үүсэх нэг сурвалж болсон юм. Түүний дараагаар 1925 онд “МАХН-аас шашин шүтлэгийн талаар баримтлах гол бодлого, товч тогтоол” хэмээх нэртэй баримт бичиг хэвлэн тархааж 1926 онд шашныг төрөөс тусгаарласан тусгай хууль батлан гаргаж шашин бол ардын эрхт төрийн гол дайсан хэмээн тойруу ба шууд утгаар сурталчлах болсон юм. Үүнээс уламжлан зарим лам нар 1925 оноос эхлэж хүрээ хийдээ орхин гарч иргэний байдлаар амь зууцгаах болжээ. Энэ бол шашныг намын үзэл суртлын хэрэгслээр эсэргүүцэхэд чиглэсэн оролдлогын эхний үр дүн байлаа. Тэр үед шашны цэвэр ариун байдал зарим талаар алдагдаж бүтээх үйлдвэрлэх идэр эрчүүд олноороо хүрээ хийдэд шавилж нийгмийн үйлдвэрлэлд үлэмж саад болж байсан нь маргаангүй боловч түүнийг хэтэрхий эрс арга хэмжээгээр таслан зогсоохыг 1924 оноос эхлэн оролдсон нь нам төрийн бодлогод гарсан алдаа байлаа. Нам төрөөс шашны нөлөөг бууруулахын тулд улс төр, үзэл суртлын ажлаас гадна хүрээ хийдийг эдийн засгийн аргаар сөхрүүлэн доройтуулах бодлого боловсруулан хэрэгжүүлэхийг оролдсон юм. Энэ талын хамгийн анхны арга хэмжээ бол сүсэгтнээс хурал номын зардлыг албадан гаргуулахыг хориглосон шийдвэр байлаа. Үүний дараах нэг томоохон шийдвэр бол 1922 оноос эхлээд жасын тарианы газрын түрээсний орлогоос улс зохих хувийг авч байх заалт юм.

Ингэж жасын тариаланд төрөөс хяналт тавьж түрээснийх нь хураамжийг өмнөх засгийн үеийнхээс нэмж урьд нь татвар бараг ногдож байгаагүй жас жавын мал сүрэгт албан татвар ногдуулах болсон зэрэг нь зөвхөн хүрээ хийдэд шавилан суудаг санваартнууд төдийгүй сүсэгтэн олны дургүйцлийг төрүүлж байв. Тиймээс ч төр засгийн бодлогыг эсэргүүцэгчдийн дотор лам хувраг, тэдний шавь нар олон байсан бөгөөд хүрээ хийдэд албан татвар ногдуулахыг эсэргүүцэн татвараас чөлөөлүүлэхийн төлөө тэмцэж байсныг төр засагт дайсагнасан үйл ажиллагаа хэмээн үзэж хараахан болохгүй юм. Яагаад гэвэл хүрээ хийдийн эдийн засгийн үйл ажиллагааг улсадашигтайгаар зохицуулах зөв зам сонгон олохын оронд бурхан шашныг төрийн гол дайсан мэтээр сурталчлаад жас жавын эдийн засгийн хүч чадлыг бууруулбал шашны нөлөө аяндаа сулрах мэтээр гэнэхэн сэтгэж байсандуг алдааны гол агуулга оршиж байлаа. Үүнийг тухайн үеийн нам төрийн удирдагчдын зарим нь зөвөөр ойлгож байсан боловч тэдний санал бодол, үзэл баримтлал

олонхийн ба Коминтерний дэмжлэг хүлээхгүй байлаа. Иймээс 1926 оноос эхлэн жас жав ард олныг мөлжиж байна хэмээн тогтмол хэвлэлд бичиж нийтлэн өргөн олонд ухуулж сурталчлах нь улам бүр нэмэгджээ.

Ялангуяа аж ахуйн хэд хэдэн чиглэлтэй, мал малын захтай баян жасыг албан татварын дарамтаар унагаах оролдлого 1927 оноос илэрхий болж ирэв. 1924-1927 он хүртэлх хугацаанд жасын малын тоо жил дараалан өсч 1927 оны эхээр 3.5 сая толгойд хүрч 10 мянган малтай жас 60 гаруй, 10 мянгаас илүү малтай жас 10 орчим болж байсан мэдээ байдаг. Жасууд өөрийн мал сүргээ бусдаар адуулуулахдаа харилцан зөвшөөрөлцөж тохирсныхоо дагуу өгөх зүйлээ өгч авах юмаа авдаг байсан бөгөөд жасын малыг хүссэн хүн бүхэн маллаж байсангүй, аль дайралдсан хүнд ямар ч жас малаа тушаан өгч албаар адуулуулдаггүй олон зууны уламжлал байлаа. Тэрхүү уламжлал 1921 оноос хойш ч хэвээр байжээ. Ажилсаг бөгөөд ихэнх тохиолдолд хөрөнгө чинээтэй айл өрхөөс шилж сонгон тэдний дур сонирхлын дагуу жасууд малаа маллуулж байлаа. Энэ нь нэг талаар ажилсаг хүний адуулсан малын араас жас санаа зовох зүйлгүй, нөгөө талаар хэрэв алдаж үрэгдүүлбэл төлөөд өгчих бэл бэнчинтэй хүнийг шилж сонгон авч байжээ. Мал малын захтай чинээлэг айл өрх гол төлөв хажуудаа хавсарга өрхтэй байсан бөгөөд тэд өөрийнхөө адуулж буй жасын малыг зарц нартаа өгч маллуулж байлаа. Энэ мэтчилэнгээр жасын малаар амь зуулгаа залгуулдаг айл өрх олон мянга байлаа. Өөрөөр хэлбэл сүсэгтний өргөсөн мал. Түүний үр төл нь эргээд олон түмний нэг хэсгийн гэдсээ тэжээх эх сурвалж болж байв. Үүнтэй холбогдуулан хэлэхэд зарим судлаачид Шар феодалууд ялангуяа сүм хийдүүд малаар дамжуулж ард олныг мөлжиж байсан юм. Энд эдийн засгийн арга зонхилж байсан нь маргаангүй” гэж дүгнэсэн байдаг. Өнгөц ажиглахад үнэхээр тийм байж болох мэт. Харин нилээд эргэцүүлбэл жасууд өөрийнхөө мэдлийн малыг бусдаар маллуулахдаа хөлс шан, ашиг тооцоогоо харилцан тохиролцож хэн хэн зөвшөөрөлдөг байсан нь тодорхой. Өөрөөр хэлбэл жасууд бусдыг мөлжиж баяжиж хөлжихийн тулд малтай байсан гэж үзэх боломжгүй байна.

Жасууд малаас гадна тариалан эрхэлж өөрийнхөө хэрэгцээг хангаад зогсохгүй бусдад худалдан ашиг орлого олж байв. Жасын тариаланд лам нар биш жирийн иргэд хааяа хятадууд ажиллаж түрээсийн журмаар хөлс ашгаа тохирон авч байв.

Мөн хол ойрын аян жин тээх, хөсөг хөдөлгөх, гар урлалын зарим зүйл үйлдэж зарж борлуулах, хааяа зарим жас мөнгө цай хүүтэй зээлдүүлж мал худалдах явдал байсан боловч бүх жасыг нийтэд нь хамарсан түгээмэл зүйл биш байлаа. Бидний санахад сүсэгтэн олны өргөсөн мал, мөнгө бусад зүйлээс бий болсон жас жав өмч хөрөнгөө аль болохоор хэмнэж бололцоогоо ашиглан арвижуулж чадвал буян үйлдэж байна хэмээн санадаг, харин сүсгээр хуримталсан хандивын сан

хөрөнгийг үрж бусниулбал бурхан шашинд цөв суулгаж байна хэмээн ухаарч ойлгодог хүмүүсийн тоо олз ашигт шунагчдаасаа түлхүүхэн байсан нь лавтай. Бид ингэж хэлэхдээ тэр үед бурхан шашинд үнэн сэтгэлээсээ итгэж бишрэгчид нь хуурамч дүр үзүүлэгчдээсээ илэрхий давамгайлж байсныг үндэс болгож байна.

Нөхцөл байдал нэгэнт ийм байгааг тухайн үеийн нам, төрийн удирдагчдын олонх нь огт хайхралгүй гагцхүү ЗХУ, Коминтерний заавар зөвлөлгөөг дагаж 1930 оноос жасын компани гэгч дуулиантай ажил өрнүүлж хүрээ хийдийн өмч мал сүргийг ядуучууд, ажил төрлийн дөрөө олоогүй шинэ тутам байгуулагдсан хамтралуудад гэрээгээр маллуулахаар хүчээр шилжүүлж дааж давшгүй хөлс ацаг албадан төлүүлэх болсон байна. Урьд нь жасууд мал адуулагч нартай тохирсныхоо үндсэн дээр хөлс шангаа ч өгдөг, алдаж осолдуулсан малаа ч төлүүлдэг байсан бол зүүнтний үед жасын удирдлага ямар ч эрхгүй болж жасын мал хорогдуулсан хүн төлөх нь бүү хэл зэмлэл ч сонсохгүй “дархан эрхтэй” болсон байна.

Ийнхүү 1929-1932 онд үргэлжилсэн зүүнтний их хийрхлийн уршгаар жасын мал эрс хорогдож 1933 оны тооллогоор 39222 толгой мал хүрээ хийдийн мэдэлд байжээ. Жич, 1930, 1931 онд Жасын мал хэд байсныг албан ёсны статистикт бичээгүй орхисон байдаг. 1932 оноос хойших хугацааны мал тооллогын дансанд 1938, 1939 оны жасын малын тоо бас байдаггүй юм. Харин 1944 оны зунаас Улаанбаатарт мөргөлийн ганц сүм нээгдэж 1946 оноос эхлэн хэд гурван малтай болсон ажээ. Тухайлбал 1946 онд тус сүмийн мэдлийн буюу жасын мал 8200 байсан бол 1947 онд 6400, 1948 онд 3500, 1949 онд 3500, 1950 онд 3200, 1951 онд 3000, 1952 онд 1700, 1953 онд 900, 1954 онд 600 болж тус тус тоолсон данс бүртгэл байна.¹⁵ Харин 1955 оноос хойш тус сүм мэдлийн малгүй болсон юм.

4. Шинэ эргэлтийн бодлого ба мал сүрэг

Өнгөрсөн зууны Монголын түүхэнд хамгийн эерэг нөлөө үзүүлсэн үйл явдлын нэг бол 1932 оны 7-р сараас 1941 онд төр засгаас эдийн засгийн салбарт хэрэгжүүлсэн цогц бодлого юм. Үүнийг шинэ эргэлтийн бодлого (ШЭБ) гэж түүхэнд нэрлэдэг. Энэ хугацаанд өргөн олны урам зориг сэргэж төр засгийн нэр хүнд дээшилж улс орны эдийн засагт нилээд ахиц гарсан билээ.

ШЭБ-ыг хэрэгжүүлэх болсны учир юу вэ? 1932 оны 4-р сараас эхлэн Монголын төвийн хэд хэдэн аймгийн ард олон төр засгийн бодлогыг эсэргүүцэж зэвсэг барьж босоцгоосон нь улс орныг бүхэлд нь хамарч болзошгүй байдалд хүрсэн учир мөн оны 5-р сард ЗХУ-ын удирдагчид онцгой анхаарч цэрэг зэвсгийн хүчээр бослогыг даржээ. Уул бослого үргэлжилсэн хугацаанд улс, хоршоолол, хувийн өмчийн салбарт үлэмж хэмжээний хохирол учирсан юм. Гэвч хохирлын хэмжээг нарийвчлан судлаагүй өдий хүр нь улс төрийн бодлоготой холбоотой юм.

¹⁵ Мөн дээрх, 54.

ШЭБ-ын Энэхүү бодлогын гол агуулга нь ардын аж ахуйтныг нийтээр дэмжих, ялангуяа урьдын адил чинээлэг хэсгийнхний үйл ажиллагааг олон зүйлээр хавчин хязгаарлах биш, харин улсын хууль дүрмийн дагууаль болохоор хөгжүүлэн дэмжихэд чиглэжээ. Чухамдаа бол 1921-1924 онд төрөөс баримталж байсан бодлогыг сэргээн хэрэгжүүлж эхэлсэн юм. Мөн зүүнтний үед албадан байгуулсан 800 шахам хамтрал, коммуна, нөхөрлөл артелиг тарааж зөвхөн сайн дураараа хүсэлт гаргасан цөөн хэдэн хамтралыг хуучин хэвээрээ үйл ажиллагаагаа явуулахыг зөвшөөрч Ардын үйлдвэрлэлийн нэгдлийн дүрмийн дагуу хамтран хөдөлмөр эрхлэх болгожээ. Мөн улсын экспортын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэхийн тулд ардын аж ахуйтнаас гэрээгээр улсад худалдах малын үнийг 25 хувь, мал аж ахуйн бүтээгдэхүүний үнийг 19 хувиар өсгөсөн байна.¹⁶

1932 оны наймдугаар сард батлагдсан “Мал, тариалангийн албан татварын тухай” хуульд зааснаас үзвэл тухайн өрхөд ногдох татварын хэмжээг малын тоогоор биш, нийт орлогыг нь баримтлах болов. Тус орны нутаг дэвсгэрийг 6 бүс болгож бүс тутамд мал бүрээс орох орлогын хэмжээг зааж, түүнийг хувьд шилжүүлэн тухайн өрхийн нийт орлогын хэмжээг тодорхойлох болжээ. Энэ нь өмнөх хуулиудыг бодвол бодит байдлыг чанд харгалзсанаараа ихээхэн давуутай байлаа. Хөлсний хөдөлмөрөөр нэмүү орлого олох нь бусдыг их бага хэмжээгээр хохироох талтайг харгалзан үзэж энэ хуульд цоо шинэ зарим заалт оруулжээ. Жишээлбэл, ямар нэгэн өрх бусдын хүчээр, өөрөөр хэлбэл, хөлсний ажилчид (зарц) хэрэглэж олсон орлогын нь 50% хувийг, хэрэв сонгуулийн эрхээ хасуулсан бол 75 хувийг хураахаар заав.

Сонгуулийн эрхээ хасуулсан хүний бүх орлогод нь татвар ногдуулахдаа 900 төгрөг хүртэл орлоготой бол ногдсон татварыг 10 хувиар, 90-2500 төгрөг хүртэл орлоготой бол 14-35 хувиар нэмж хураахаар заажээ. Үүнээс үзэхэд жирийн ард, сонгуулийн эрхгүй хүн хоёроос хураах татварын хэмжээ нилээд зөрүүтэй нь мэдэгдэж байна. Жишээлбэл, жирийн ард хүн 900 төгрөгийн орлоготой бол татварын ногдол төлөхдөө малын үнийнхээ төгрөг тутамд 9 мөнгө хураалгах ёстой байхад сонгуулийн эрхгүй хүн 10 мөнгө, өөрөөр хэлбэл, 10 хувийн илүү төлөх болжээ.

Ийнхүү шинэ эргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх явцад улс орны эдийн засагт үйлчилж байсан хууль эрхийн олон баримт бичгийг (бүрэн бус бүртгэлээр 40 гаруй) хянан өөрчилсөн бөгөөд тэдний гол агуулга нь ардын аж ахуйтан, хувийн жижиг үйлдвэр, худалдаа эрхлэгчдийн хувийн сонирхлыг улсын эрх ашигтай зөвөөр хослоход чиглэж байлаа. 1932-1933 онд энэ асуудалд шууд буюу дам холбогдох арав орчим дүрэм, заавар, тогтоол боловсруулжээ. Жишээлбэл, “Мал ба тариаланг эрхлэх энгийн аж ахуйтнаас хөлсний хүчнийг хэрхэн хэрэглэх тухай дүрэм”, “Хот ба хөдөө суурин газрын малаас хураах орон нутгийн татварын тухай хууль”,

¹⁶ БНМАУ-ын 18-р бага хурал: Илтгэл тогтоол, УБ, 1933, 26.

“Монгол улсын морин өртөөний албаны тухай хууль” зэргийг дурдаж болно. 1933 оноос эхлэн мал аж ахуйн албан татварыг нийт орлогоос нь хураадаг зарчмыг өөрчилж, улсын бүх нутгийг 3 бүс болгож аж ахуйтны бэлэн байгаа малын тоо толгойд ногдуулж хураах болов. 1933-1939 онд дээрх хуулийн зарим заалтыг бага зэрэг өөрчлөн дагаж шийтгүүлж байлаа. Тэгэхдээ ядуу, дундаж ахуйтныг дэмжих, чинээлэг, баян өрхийн орлогыг хязгаарлах бодлогоо мөн л үргэлжлүүлсээр байв. Жишээ нь, 1932 оны хуульд 501-750 төгрөгийн орлоготой өрхийн ногдох татварын төгрөг тутамд дунджаар 6,1 мөнгө ногдож байсан бол 1939 оны татвараар 3 мөнгө ногдох болж 2 дахин багасгасан байна. Түүнчлэн 2500 төгрөгийн орлоготой өрхийн ногдол татварын нэг төгрөг тутмаас 25 мөнгө хурааж байсан бол 1933 онд 17 мөнгө болж 32 хувиар багасгасан байна.

1932 оноос хойш ардын аж ахуйтанд ногдуулан хурааж байсан албан татварын гол нь ядуу, дундаж ахуйтны малаа өсгөх сонирхлыг дээшлүүлэх, ардын цэргийн албан хаагчдын ар гэрийнхнийг эдийн засгийн хувьд тэтгэн дэмжих, ялангуяа малын хашаа, саравч, худаг ус гаргах, өвс хадлан бэлтгэх, малын үүлдэр угсааг сайжруулах, төлийг бүрэн бойжуулахад тодорхой амжилт гаргасан аж ахуйтны албан татварын нилээд хувийг хөнгөвчилж байсан нь зохих үр дүнгээ өгч 1933 онд улсын мал бүхий нийт өрхийн 55,3 хувь нь албан татвараас чөлөөлөгдсөн бөгөөд татвар төлбөл зохих өрхийн 37 хувьд хөнгөлөлт үзүүлсэн байна.

Ийнхүү шинэ эргэлтийн бодлогын үрээр зөвхөн 1934 онд тус улсын мал сүрэг 22,5 сая болж 1932 оныхоос 28 хувиар өсгөж байлаа. Дээрх хэд хэдэн арга хэмжээнээс гадна мал эмнэлгийн салбарыг олшруулж 1934 онд 42 болгож 1932 оныхоос 11-ээр нэмэгдүүлжээ. Мөн малын эмч нар энэ хугацаанд 17-гоос 104 болж мал эмнэлэгт зориулсан төсөв 1933 онд 1,4 сая төгрөгт хүрсэн байна. Эдгээр шинэ арга хэмжээ зохих үр дүнгээ өгч 1932-1941 онд тус улсын мал сүрэг жил дараалан өсөж 27,5 сая толгойд хүрсэн байна. Ийнхүү мал сүрэг тогтвортой өсөж байсан гол шалтгаан бол шинэ эргэлтийн бодлого нь малчдын малаа өсгөх идэвх сонирхлыг дээшлүүлэхэд тууштай анхаарч байсны үр өгөөж байлаа.

Гэвч шинэ эргэлтийн үед хүрээ хийдийн аж ахуй-жас жавын малын тоо 1933 оноос эхлэн жил дараалан хорогдсоор байв. Тухайлбал 1933 онд жасын бүх мал 392322 болсон нь 1946 онд 8208 болтлоо цөөрч 47 дахин хорогдсон юм.¹⁷ Энэ бол МАХН-аас шашныг хяхан хавчиж үйл ажиллагааг хориглож байсны шууд үр дагавар байсныг өмнө дурдсан билээ.

Малын тоо толгойг баримтлан мал аж ахуйн албан татвар хурааж байснаар 1940 он гэхэд ардын аж ахуйтны мал өмчлөлтөд нилээд өөрчлөлт гарах болов. Хэрэв 1927 онд малтай бүх өрхийн 35,4 хувь нь 1-10 хүртэл бодтой байсан бол 1939 онд 4,4% болж, 200-300 бодтой өрх 1067 байсан нь 895 буюу 17,2%-иар 300-

¹⁷ Печников А.М, Животноводство МНР. *Материалы государственной статистики*, Вып.1, 1947,8.

500 бодтой өрх нь 514-өөс 239 буюу 46,4%-иар тус тус цөөрчээ. Аж ахуйтны хамгийн дээд группын тоо бүр ч цөөрчээ. Жишээлбэл, 1929 онд 500-гаас дээш бодтой өрх 254 байсан нь 1939 онд ердөө 66 болж 3,8 дахин хорогджээ. Үүний үр дүн даж ахуйтны туйлшрал багасч, ядуу аж ахуйтан цөөрч, дундаж ахуйтан нилээд нэмэгдсэн юм. Өөрөөр хэлбэл ардын аж ахуйтныг дундчлах бодлого амжилттай биелж баян ба ядуу аж ахуйтны бүлэг ойртож дунд аж ахуйн хэмжээнд төвлөрч байсныг харуулж байна.

Миний бодоход 1932 оны зун эхэлсэн шинэ эргэлтийн бодлого 1941 оны зун ЗСБНХУ, Германы хооронд дайн эхэлсэн үед дуусгавар болсон бололтой. Өөрөөр хэлбэл 1941 оны 6 дугаар сарын сүүлчээс эхлэж мал аж ахуйн талаар төр засгаас баримтлан хэрэгжүүлж байсан бодлого эрс өөрчлөгдөж малын тоо толгой өсгөхийг анхаарч байсан боловч малын ноос, түүхий эдийг аль болохоор бүрэн дүүрэн ашиглахад гол бодлогоо чиглүүлж ирсэн байна.

5. Монголын мал сүрэг 1941-1954 онд

Энэ хугацаанд мал сүргийн өсөлт тогтворгүй буюу буурах хандлагатай бол зөвхөн 1941-1942 онд 27,5 саяас 24,5 сая болж 10,1%-иар, 1942-45 онд 24,5 саяас 20 сая болж 18,4%-иар хорогджээ. Энэ нь хоёр гол шалтгаантай. Үүнд нэгдүгээрт ЗХУ-аас импортлодог хүнсний бүтээгдэхүүн 1941 оноос эхлэн эрс багассан учир малыг хүнсэнд хэрэглэх нь нэмэгдсэн, хоёрдугаарт 1944 оны их зуд Монгол Улсын бүх нутгийг хамарсан явдал байлаа. Малын тоо толгойн хорогдол зогсоогүй байхад 1944-48 онд төр засгийн шийдвэрээр улсын бэлтгэлийн зүйлийг бүх аж ахуйтай тэгшитгэн ногдуулах болсноор дурдан буй хугацаанд дундаж аж ахуйтны тоо цөөрч чинээлэг аж ахуйтны өрх тутамд ногдох малын тоо өссөнийг Хүснэгт 2-оор үзүүлье.

Хүснэгт 2-оос үзэхэд, 1944-1948 онд нийт аж ахуйтны дотор 300-гаас дээш малтай өрхийн эзлэх хувь буурсан боловч тэдний нэг аж ахуйтанд ногдож буй малын тоо дунджаар 5,9 хувиар буюу 25 толгойгоор ялангуяа, сүүлчийн дөрвөн жилд нь (1945-1948 онд) 3,1-3,9 болж малын тоо 14,2-18,7%-иар нэмэгджээ. Гэтэл нийт аж ахуйтны дотор 1944-1948 онд малгүй ба 50 хүртэл малтай өрхийн эзлэх хувь 30,0 байснаа 40,4 болж 10,4 хувиар нэмэгдэж, дундаж ахуйтан 64,8-55,7 болж дөнгөж 9,1 хувиар багасч улсын нийт малын тоо ч гэсэн 8,5 хувиар буюу 3,4 саяар хорогдсон байна. Ингэж албан татвар, улсын бэлтгэлийн зүйлийг тэгшитгэн ногдуулж байснаас сөрөг нөлөө гарах болсон нь төр, засгаас хөдөө аж ахуйн талаар авсан зарим арга хэмжээг өөрчлөхийг зүй ёсоор шаардав.

Хүснэгт 2.

	Ардын аж ахуйтны эдийн засгийн бүлэглэл	Он				
		1944	1945	1946	1947	1948
Ядуу аж ахуйтан	Малгүй өрх /%/	2,0	2,5	1,7	1,8	2,3
	50 хүртэл малтай өрх	28,0	35,7	35,6	37,1	38,1
	Нийт мал сүрэгт тэдний малын эзлэх хувь	6,6	10,4	9,9	10,1	10,3
	Нэг аж ахуйтанд ногдох мал	26,6	26,4	26,1	25,6	25,3
Дунд аж ахуйтан	51-100 хүртэл малтай	64,8	58,7	59,2	57,5	55,7
	Нийт мал сүрэгт тэдний эзлэх хувь	73,1	75,4	73,8	72,9	71,0
	Нэг аж ахуйтанд ногдох мал	126,8	116,6	117,2	119,1	119,2
Чинээлэг аж ахуйтан	300-гаас дээш малтай	5,2	3,1	3,5	3,6	3,9
	Нийт мал сүрэгт тэдний эзлэх хувь	20,3	14,2	16,3	17,0	18,7
	Нэг аж ахуйтанд ногдох мал	423,0	418,4	436,9	445,3	448,0
	Мал бүхий нэг аж ахуйтанд ногдох малын дундаж тоо	112,1	90,8	94,0	93,9	93,6

Ийм ч учраас 1949 оноос эхлэн мал аж ахуйн албан татварыг хураахдаа аж ахуйтны малын тоогоор өсгөн нэмэгдүүлэх зарчмыг сэргээн баримтлах болов. 500 ба түүнээс дээш малтай өрхийн татварын хэмжээ нилээд нэмэгдэж, 20-200 хүртэл малтай өрхөд ногдох татварын хэмжээ үлэмж багасав. Гэхдээ улсын төлөвлөгөөгөөр өсгөсөн байх ёстой малын тоог чанд харгалзсан хэвээр байжээ. Иймээс аж ахуйтны задрал зогссонгүй зарим сөрөг хандлага улам гүнзгийрэв. Жишээлбэл, 1953 онд ардын аж ахуйтны дотор ядуу аж ахуйтны эзлэх тоо 3,1 дахин (4231-13248) нэмэгдэж дунд аж ахуйтны 64,4-51,0%-ийг эзлэх болж хорогдов. Гэтэл энэ хугацаанд бүх аж ахуйтны дотор 300-гаас дээш малтай өрхийн эзлэх хувь 1%-иар өсөж 13255 болжээ. Ялангуяа 501-ээс дээш малтай өрх 65,6%-иар өсөж 2171 байснаа 3307 болж үлэмж өссөн байна.

Улсын бэлтгэлийн хэмжээг төлөвлөгөөт малын тоогоор бодож ногдуулж байсны улмаас малын тоог бүх аргаар өсгөн нэмэгдүүлэх, хөдөлмөрчин ардын аж ахуйтны зохих сонирхлыг татахгүй болжээ. Үүнээс үндэслэн 1950 он хүртэл дагаж мөрдсөн албан татварын системд эрс өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага урган гарсан байна. 1950 онд мал аж ахуйн татварын шинэ хуулийг батлан гаргав. Уг хуулиар ардын аж ахуйтны малтай бүх өрхийг 6 групп болгож таван хошуу мал тус бүрд 25 мөнгөнөөс 9 төгрөг хүртэл хэмжээний татвар ногдуулж байв. Энэ хуулийн заалтаас үзэхэд ядуу, баян аж ахуйтнаас хураах татварын хэмжээ нилээд

зааг ялгаатай болж, ялангуяа ядуу аж ахуйтныг аль болохоор тэтгэн дэмжих, 201-ээс дээш толгой малтай өрхийн ногдлыг нилээд их хэмжээтэй тогтоожээ. Ядуу ба 501-ээс дээш малтай өрхийн нэг толгой малд ногдох татварын хэмжээг мал тус бүрээр харьцуулбал: хонинд 8 дахин, үхэрт 7 дахин, ямаанд 6 дахин, адуунд 4 дахин, гэмээнд 3 дахин их байлаа.¹⁸ Гэхдээ 500-гаас дээш малтай бүх өрхийг ганц групп болгосон нь нэг талаар ардын аж ахуйтны дээд хэсгийг хязгаарлах бодлогод төдий л нийлэмжтэй болоогүй гэх үндэстэй. Яагаад гэвэл 501, 1000 малтай хоёр өрхийн нэг толгой малд ногдох татварын хэмжээнд ямар ч ялгаа байхгүй байлаа. Нөгөө талаар 201-500 хүртэл малтай өрхийг нэг групп болгож ижил хэмжээний татвар хурааж байсан нь дундаж ахуйтны хувьд хохиролтой, чинээлэг аж ахуйтанд ашигтай байв. Энэ нь дундаж ахуйтныг малаа өсгөх сонирхлыг боогдуулахад хүрсэн юм.

1950-1953 онд нийт мал сүрэг 0,8 хувиар өссөн боловч ардын хувийн аж ахуйтны мал 0,4 хувиар хорогдож, таваарын бүтээгдэхүүний хамгийн ашиг шимтэй мал-үхэр нийт дүнгээрээ 9,8%-иар, ардын хувийн аж ахуйтны салбарт 11,9%-иар тус тус хорогдож, улсын хэмжээгээр хонь 1,8%-иар өссөн байхад хувийн аж ахуйтны хонь 0,7%-иар хорогджээ. Ингэж 1950 оноос хойш мөрдсөн мал аж ахуйн албан татвар зохих үр дүн өгөөгүй учраас нилээд өөрчилсөн шинэ хуулийг 1954 оноос мөрдөх болов.

МАХН-ын Төв Хорооноос 1954 оны гуравдугаар сард “Ардын аж ахуй ба ардын үйлдвэрлэлийн нэгдлүүдээс мал аж ахуйн үйлдэхүүнийг заавал тушаах тухай ба мал аж ахуйн албан татварын тухай” гаргасан тогтоолд “улсын албан татвар, бэлтгэлийн бодлого нь ардын хөдөлмөрийн (ядуу, дунд) аж ахуйтны байдлыг дээшлүүлэхийн хамт мөлжигч этгээдүүдийг ардын аж ахуйгаас аажмаар хязгаарлан шахаж гаргах, хөдөө аж ахуйн социалист секторыг бүх талаар дэмжин бэхжүүлэх, тус орны мал аж ахуйг дээд хэмжээгээр хөгжүүлэх ба хөдөлмөрчдийн аж байдлыг улам сайжруулах зорилгуудад бүрэн дүүрэн тохирохуйцаар өөрчлөгдсөн байх ёстой” гэж заав. Үүний дагуу мөн оны гуравдугаар сард “Ардын аж ахуйтан ба ардын нэгдлүүдээс мал, ноос, сүүг улсад албан журмаар нийлүүлэх тухай хууль”, “Улсад албан журмаар нийлүүлэх мал аж ахуйн үйлдэхүүн ба мал аж ахуйн албан татварын өнгөрсөн онуудын дутууг ардын аж ахуйтнаас хасах тухай тогтоол” зэргийг батлан 1959 он хүртэл дагаж мөрдсөн юм. Эдгээр хуулиар 20 хүртэл малтай аж ахуйтныг албан татвараас чөлөөлж 21-1000 хүртэл малтай аж ахуйтныг 10 групп болгон ногдол татварын хэмжээ нь 100 төгрөгөөс хэтрэхгүй бол татвараас чөлөөлөх, 8 хүртэл насны 4 хүүхэдтэй бол малын тоог харгалзахгүйгээр ногдол татварыг 10%-иар, 8 хүртэл насны хүүхэдтэй цэргийн ар гэрийг 25%-иар тус тус хөнгөлөхөөр заасан байна. Гэвч шинэ хуульд зарим нэгэн зүйлийг дутуу анхаарчээ. Тухайлбал, уг аж ахуйтан нутаг дэвсгэрийн ямар бүсэд, зах зээлээс хэр

¹⁸ Үнэн, 1950-VI-10.

3. Лонжид

зэрэг хол ойр орших, таваарлаг чанартай малын эзлэх хувь зэргийг харгалзалгүй нийт 21-50 малтай өрхийн нэг толгой малд ногдох татварын хэмжээг 50%-иар, 51-100 хүртэл малтай өрхийн нэг толгой малд ногдох татварыг 9,3-20%-иар тус тус хөнгөлсөн нь ч тэдний мал өсөх, аж байдлын төвшин дээшлэхэд тодорхой нөлөө болсон нь мэдээж билээ. 201-500 малтай аж ахуйтны нэг толгой малд ногдож байсан татварын хэмжээ 1950, 1954 онд хэрхэн өөрчлөгдсөнийг үзүүлбэл дараах хүснэгт болно.

Хүснэгт 3.

Аж ахуйтны групп	Нэг толгой малд ногдох татварын хэмжээ (төг)									
	Тэмээ		адуу		үхэр		хонь		ямаа	
	1950	1954	1950	1954	1950	1954	1950	1954	1950	1954
101-200 малтай	7	7.50	6	5.50	5	4.50	1.50	1.35	1	0.87
201-500 малтай	8	8.50	7	7.50	6	6.50	1.75	1.86	1.25	1.50
501 ба дээш	9	9.67	8	8.60	7	7.52	2.00	2.15	1.50	1.87
Дундаж хэмжээ	8	8.55	7	7.20	6	6.17	1.75	1.78	1.25	1.41

Хүснэгтээс үзэхэд, 1950 оны татварын хуулиар 101-200 хүртэл малтай өрхийн тэмээнд дунджаар 8 төгрөг ногдож байсан бол 1954 онд 8 төгрөг 50 мөнгө болж 6,8 хувиар, хонинд 1,7 хувиар үхэр, адуунд тус бүр 2,8 хувиар нэмэгджээ. Өөрөөр хэлбэл, адуунаас бусад нэг толгой малд ногдох албан татвар 1,7-12,8 хувиар нэмэгдсэн байна. 1954 оны албан татварын өөрчлөлтөөр 301-ээс дээш толгой малтай өрх, ядуу аж ахуйтан хоёрын ижил төрлийн малд ногдох татварын хэмжээг харьцуулахад нилээд зөрөөтэй байна. Жишээлбэл, 21-50 малтай өрхийн нэг тэмээнд 2 төгрөг 50 мөнгө ногдож байхад 1000-аас дээш малтай өрхөд 10 төгрөг 35 мөнгө болж хоёр өрхийн тэмээнд ногдох татварын зөрөө нь 7 төгрөг 85 мөнгө буюу 4.1 дахин, адуунд 9 төгрөг 20 мөнгө буюу 4,6 дахин, үхэрт 7,7 дахин, хонинд 6,5 дахин, ямаанд 8 дахин их ногдож байв. Өөрөөр хэлбэл, 21-50 толгой малтай өрхийн нэг тэмээнд ногдох татвар нь (2 төгрөг 50 мөнгө) 1000-аас дээш толгой малтай аж ахуйтны нэг хонинд ногдох татвартай (2 төгрөг 30 мөнгө) бараг ижил 20 мөнгө буюу зөвхөн 8 хувийн зөрөөтэй байна. 1959 оныг хүртэл үйлчилсэн энэ хуулиар нь 301-ээс дээш малтай өрхөд ногдох татварыг эрс нэмэгдүүлсэн нь тэр үед төр засаг олон малтай баян чинээлэг өрхийг хязгаарлахад гол анхаарлаа чиглүүлж байсны нотолгоо юм. Жишээлбэл, дунджаар бодоход 50-иад оны эцэст, ядуу, дундаж ахуйтнууд мал аж ахуйгаас орох орлогынхоо 3,3 хувийг, баян өрх 35,8 хувийг улсын албан татварт төлж байлаа. Татварын хэмжээ эрс нэмэгдсэнээс болж баян аж ахуйтнууд ялангуяа 700-гаас дээш толгой малтай өрх, тэдний мэдэлд буй малын нь тоо нилээд цөөрч байв. Г.С. Матвеевагийн судалгаанаас үзэхэд 1953-1956 онд дурдсан аж ахуйтны тоо 39,7 хувиар малын нь тоо 49,5 хувиар

хорогджээ. Гэхдээ жижиг татварын үйлдвэрлэл оршиж буй нөхцөлд ардын аж ахуйтны нийгмийн группт ялгарал гарах нь зайлшгүй учраас ядуу хоосон, баян өрхийн аль аль нь ерөнхийдөө цөөрөвч бүрэн арилахгүй буюу зарим үед нэмэгдэх хандлага байсан нь төр засгийн бодлого төдий л оновчтой бус байсныг харуулна. Иймд, төрөөс хөдөөгийн хоосон ядуу, дунд аж ахуйтныг дэмжих тэдний малын тоо толгойг өсгөн олшруулахад аль болох түлхэц үзүүлэхэд чиглэсэн хэд хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлэв. Тухайлбал, 1954 оны гуравдугаар сард Сайднарын Зөвлөлөөс гаргасан шийдвэрт ардын аж ахуйтнаас улсад тушаах албан журмын мах, ноос, сүүний дутууг хүчингүй болгохдоо 1953 оны улсын мал тооллогоор 300 хүртэл малтай байсан өрхөөс бүрмөсөн хасч, 300-500 хүртэл малтай аж ахуйтны дутуу зүйлийн 50 хувийг хөнгөлжээ. Харин 500-гаас дээш малгай өрхийн дутуу зүйлийг бүрэн төлүүлэхээр заав.

6. Бэлтгэлийн бодлого ба мал сүрэг

Хөдөөгийн баян чинээлэг аж ахуйтныг албан татвараас гадна улсын бэлтгэлийн бодлогыг тууштай хэрэглэсэн юм. 1941 он хүртэл мал аж ахуйн бүтээгдэхүүнийг сайн дурын зарчим, харилцан тохирсон гэрээний үндсэн дээр бэлтгэж байлаа. 1941 оноос ноос, сүүг улсадалбан журмаар бэлтгэх систем нэвтэрч эхэллээ.

1941 оны нэгдүгээр сард Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн баталсан хуулийн дагуу бүх малыг нь хониндшилжүүлэн бодоход (1 тэмээ 8 хонь, 2 ямаа=1 хонь) 100 толгой хүрэхгүй бол түүнийг албан журмын ноос бэлтгэхээс чөлөөлж 100-гаас дээш хоньтой бол хонь бүрт 1 кг ноос ноогдуулж байв. Бэлтгэлийн ноосны үнийг 1940 онтой харьцуулахад 40,6%-иар нэмэгдүүлсний дээр ноос тушаасан өрхөд тухайн үед ховор байсан цай, дүнсэн тамхи бусад барааг чөлөөтэй худалдаж байв.

1944 оны хоёрдугаар сард Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор ардын аж ахуйтнууд “Улсад мал заавал нийлүүлэн тушааж байх тухай хуулийг” батлав. Энэ хуулийн ёсоор малтай бүх өрх улсад мал бэлтгэж байх болов. Тэгэхдээ малын тоо толгой, хөрөнгө чинээг харгалзахгүйгээр 9 хониноос 1 хонь, 9 ямаанаас 1 ямаа, 12 үхэр тутмаас 1 үхэр тушаахаар ногдуулж байжээ. Хэрэв нэг айлын бүх үхэр нь 12 толгой хүрэхгүй бол өөр айлын үхэртэй нэгтгэн 12 болгож дундаасаа нэг үхэр тушаах заавартай байв. Улсад бэлтгэх хонь, ямаа нь заавал 2 шүдтэй буюу түүнээс дээш үхэр нь 2-4 шүдтэй байхыг чанд заасан болзол болон аж ахуйтны малын тоо, ам бүлийн олон цөөнийг үл харгалзан бүх аж ахуйтанд ижил хэмжээний ногдол өгч байсан нь аж ахуйтны нийгмийн ялгарлыг хүчтэй болгоход нөлөөлөв. Учир нь, улсад бэлтгэх ёстой насны мал үгүй буюу дутсан хүмүүс улсын бэлтгэлийн даалгаврыг гүйцэтгэхийн тулд баячуудаас хэрэгцээт малаа өндөр үнээр

худалдан авах,эсвэл 2-3 мал өгч байж бэлтгэлдтэнцэх нас шүдний ганц малыг олж бэлтгэлд тушааж байлаа. Үүнээс болж аж ахуйтныг зарим хэсэг нилээд баяжих хандлагатай болж байхад ядуу, дунд аж ахуйтны заримынх нь мал улам цөөрөхөд хүрч байв. Жишээлбэл,Ховд аймгийн Алтай суманд зарим хүн бэлтгэлийн насны нэг эр хонийг 2 эр төлгөөр,эсвэл 2 хонийг 5 хургаар сольж наймаа хийсээр хэдхэн жилийн дотор баяжиж хөлжсөн тухай зарим хүмүүс дурсан ярьж байв. Мөн улсын бэлтгэлд тушаах малын тэнцэх эсэхийг уг малын шүдээр тодорхойлж байсан үед зарим хүмүүс малынхаа шүдийг зориуд сугачиж бэлтгэлд тэнцүүлэхийг оролдоод тэр нь илэрч шүүхээр шийтгүүлэх явдал Увс,Ховд,Өвөрхангай аймгийн зарим суманд гарч байсан тухай аман мэдээ бий. Ер нь ийм тохиолдол орон нутагт нилээд түгээмэл шинжтэй байжээ. Иймээс мал бэлтгэлийн журамд зарим өөрчлөлт оруулж 1946 оны эхээр шинэ хууль баталжээ. Уг хуульд зааснаар үхэр тутмаас 13 кг мах,хонь бүрээс 4 кг,ямаа бүрээс 2,5 кг мах бэлтгэхээр бодож бэлтгэлийн мал тушааж байх болов. 1947 оны гуравдугаар сард Улсын Бага Хурлын шийдвэрээр 20 ба түүнээс доош бог эсвэл 5-аас илүүгүй үхэртэй аж ахуйтан болон мал бүхий улс, хоршооллын байгууллага бүр өөхөн тосыг албан журмаар бэлтгэх болов. Тэгэхдээ үхэр тутамд 500 грамм,бог тутамд 100 грамм тос бэлтгэх ёстой. Харин мах худалдаалдаг хувийн худалдаачид нядалсан үхэр бүрээс 5 кг, хонь бүрээс 1 кг,ямаа бүрээс 500 грамм өөхөн тос заавал бэлтгэж байх болов. Энэ хуульд ардын аж ахуйтны малынх нь тоог үл харгалзан малын төрөлд ижил хэмжээтэй ногдуулж байсан боловч хувийн худалдаа эрхлэгчдээс улсад бэлтгэх өөхөн тосны хэмжээ ардын аж ахуйтны ногдлоос харьцуулахад 5-10 дахин их байв. 1941-1947 онд улсад албан журмаар бэлтгэдэг мал,ноос,өөхөн тосыг бүх аж ахуйтанд малын төрөл тутамд ижил хэмжээтэй тэгшитгэн ногдуулж байсан систем нь нийт ардын аж ахуйтны сонирхолд зохистой нийцээгүй учир 1948 оноос эхэлж малын тоо толгойг харгалзан өсгөн нэмэгдүүлэх журмаар хувиарлан ногдуулах болов. Энэхүү шинэ журмаар 30 хүртэл толгой малтай өрх хонь тутмаас 300 грамм ноос бэлтгэж байхад 500-гаас дээш малтай аж ахуйтны нэг хонинд 1250 грамм ноос ногдуулах болсон нь ядууаж ахуйтнаас даруй 4 дахин илүү болж байв. Уг систем 1954 он хүртэл үйлчилж хувийн аж ахуйтны нөөц бололцоог дайчлахад тодорхой нөлөөлсөн юм. Гэвч ногдлыг өгөхдөө бэлэн байгаа малын тоогоор бус харин улсаас өгсөн төлөвлөгөөгөөр өсөж нэмэгдсэн байх ёстой малын тоог баримталж байсан нь мал аж ахуйг хөгжүүлэхэд саад болжээ. Энэ тухай МАХН-ын Төв Хорооны зарим бүгд хурал,ба МАХН-ын XII их хурал дээр ч тэмдэглэж байв.

Чадал багатай аж ахуйтныг дэмжих, баян өрхийг хязгаарлахад улсын бэлтгэлийн бодлогыг чиглүүлэх зорилгоор 1954 оноос эхэлж ардын аж ахуйтнаас улсад албан журмаар нийлүүлдэг мах буюу мал ноос, сүүний ногдлын хэмжээг нилээд өөрчилж аж ахуйтны малын тоо толгойн хэмжээг баримтлан тогтоох болов. Үүнийг дор үзүүлбэл,Хүснэгт 4,5 болно.

Монголын төр ба мал сүрэг (1921-1959)

Хүснэгт 4.

Аж ахуйтныг бодын тоогоор ангилсан нь	Нэг толгой малаас нийлүүлэх мах (кг)				Сүү (литр)
	Үхрийн мах	Хонины мах	Ямааны мах	Адууны мах (хонь, ямааны махаар нөхнө)	
1. 11-20	20	4,0	3,3	3,8	60
2. 31-60	24	4,6	4,1	4,1	65
3. 61-100	28	5,2	4,0	4,5	70
4. 101-150	32	5,8	4,4	5,0	75
5. 151-260	38	6,8	5,4	6,0	85
6. 260-аас дээш	45	8,0	6,6	7,5	100
7. Дундаж хэмжээ	32,5	6,0	4,95	5,65	80,0

Хүснэгт 5.

Аж ахуйтныг бодын тоогоор ангилсан нь	Нэг толгой малаас нийлүүлэх ноос (кг)			
	Тэмээний ноос	Хонины ноос	Ямааны хялгас	Ямааны ноолуур
1.1-10	4,0	0,80	0,17	0,20
2. 11-30	4,2	1,00	0,18	0,21
3. 31-60	4,3	1,15	0,19	0,23
4. 61-100	4,5	1,25	0,20	0,24
5. 101-150	4,7	1,35	0,22	0,27
6. [151-260	5,0	1,45	0,26	0,31
7. 260-аас дээш	5,5	1,50	0,31	0,37
Дундаж хэмжээ	4,7	1,15	0,24	0,28

Дээрх хоёр хүснэгтээс үзэхэд цөөн малтай аж ахуйтанд хамгийн бага хэмжээтэй ногдож байна. Харин малын тоо олшрох тутам ногдлын хэмжээ нэмэгдсээр байна. Жишээлбэл, нэгдүгээр группын өрхийн нэг хонинд ногдох ноос хамгийн дээд групптэй харьцуулахад 47,3 хувь, ямааны ноолуур, хялгас 45,2 хувь, тэмээний ноос 27,3 хувиар тус тус бага байна. Махны ногдол хэмжээ нь аж ахуйтны групп тус бүрийн хооронд нилээд ялгаатай, ноосны ногдлын зөрүүгээс ч их байв. Жишээлбэл, гурван төрлийн малд ногдуулж байсан махны хэмжээг аж ахуйтны доод, дээд хоёр групп хооронд харьцуулахад 1,9-2,5 дахин их зөрөөтэй, сүүний хувьд 40 хувийн зөрөөтэй болж байна. Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдээс улсад бэлтгэх ноос, мах, сүүний хэмжээ нь ардын хувийн аж ахуйтны

зургаан группийн дундаж хэмжээнээс 7,1 кг буюу 21,9 хувиар бага, хамгийн дээд группийнхээс 47,7 хувиар бага байлаа. Сүүний хувьд бол ХААН-ийн гишүүний нэг үнээнээс улсад тушаах сүүний хэмжээ нь (65 л) хувийн аж ахуйтны дундаж ногдлоос 9,1 литрээр, хамгийн дээд группийнхээс 35 литрээр бага байв.

1954 оноос эхлэн мөрдөх болсон энэ хуулийн бас нэг шинэ зүйл бол зөвхөн урьд оны тооллогоор бэлэн байсан малд бүтээгдэхүүн ногдуулах болов. 10-аас хэтрэхгүй малтай бүх аж ахуйтныг сүү, махны ногдлоос чөлөөлөх болсон нь ард түмний хүсэл сонирхолд бодитой нийцэж тэдний аж байдлыг дээшлүүлэх явдалд зохих түлхэц үзүүлсэн юм.

7. Баячууд, мал сүрэг

1929 оны 1 дүгээр сард хуралдаж зүүнтний завхрал нугалааг хурдасгасан БНМАУ-ын V их хурлаас 1929 оны 1 дүгээр сарын 14-нд гаргасан тогтоолд зааснаар улсын “больницод эмчлүүлэх хөрөнгө баялаг этгээдүүдээс сүйтгэлийг хураах болгосугай”¹⁹ гэж заасан нь баян малчдыг төрөөс хавчин хяхах анхны шийдвэр байлаа. Гэвч ШЭБ-оор үүнийг цуцалсан боловч баян малчид ядуу, дунд аж ахуйтны адил эрх эдлэж чадахгүй байлаа. Зөвхөн 1944 оны намар тэднийг улс төрийн эрхтэй болгосон боловч аж ахуйнх нь орлого ба малын хөлийн татвар нь жирийн айл өрхийнхөөс ямагтилүү байсныг өмнө дурдсан билээ. Харин 1941 онд Зөвлөлт Германы хоорондох дайн дэгдэх нь гарцаагүй болсон тэр үеэс эхлэн баян малчдыг дэмжих хандлагатай болжээ. Энэ нь ч хэд хэдэн шалтгаантай. Тухайлбал, 1939 онд В.И.Сталин Монголын удирдагчдыг Москвад дуудан аваачиж олон зүйлийн даалгавар өгснийхөө дотор мал сүргээ онцгой анхаарч ойрын ирээдүйд 200 сая толгойд хүргэ хэмээн тулгасан байна. Тиймээс ч 1940 оны хавар хуралдсан МАХН-ын X их хурлаас мөнөөх В.И.Сталины даалгаврын ёсоор 200 сая малтай болох хэзээ ч үл биелэх зорилт дэвшүүлсэн юм. Уг нь монголын мал сүрэг хэчнээн их олширч өсөж үржвэл ардиргэддээ хэмжээлшгүй тус нөлөөтэй нь мэдээж юм. Гэвч тус орны ус бэлчээрийн хүрэлцээ, жил тутам өсдөг дундаж хэмжээ зэргийг бодохоор В.И.Сталины даалгавар, зөвлөлгөө бодит байдалд дэндүү авцалдахгүй нь илэрхий билээ.

Энд нэг зүйлийг зориуд тэмдэглэхэд Монгол улсын малыг 200 сая хүртэл өсгөнө гэдэг бол үл бүтэх хийрхэл хэмээн санаа бодлоо ярьсан оюутан Пунцаг, багш Лигдэнгийн Балжир нарыг эсэргүү хэмээн яллаж шорон гянданд суулгаж байсан нь төр засгийн нэгэн цагийн эндэгдэл боловч үүнийг хойчийн хүмүүс мэдэж байхад хэрэгтэй гэж үзлээ. Харин тэрхүү Пунцагхожмоо Герман улсад суралцаж биологич мэргэжил эзэмшин, шинжлэх ухааны доктор профессор, Л.Балжир Монгол Улсын гавьяат багш болсныг ч бас энд тэмдэглэхэд юуны илүүц болох аж.

¹⁹ БНМАУ-ын их бага хурлын зарим тогтоол шийдвэрийн эмхэтгэл, УБ, 1959, 98.

В.И.Сталин ЗХУ-ын зарим үйлдвэрийн хэрэгцээт ноос түүхий эдийг Монголоос хангах боломжтой хэмээн үзэж түүнийгээ Х.Чойбалсан нарт анхааруулсанд 1941 оноос эхлэж малтай бүх өрхөд ноосыг улсын алба болгон бэлтгүүлэх болов. Тиймээс мал сүргийн тоо толгойг түргэн өсгөх гарцаагүй шаардлага тулгарч ирэхэд тэр үеийн Монголын удирдагчид юуны өмнө малч хичээнгүй ажилсагийнхаа хүчээр бэлжиж хөлжсөн малчдынхаа урам зоригийг сэргээхээр шийдвэрлэжээ. Уг нь улсын сайн малчдын зөвлөгөөн 1930-аад оны дундуур нэг удаа хуралдсан байдаг бөгөөд тэр тухай ганцхан өгүүлбэр хэлэх нь илүүц бус билээ.

Малч үйл ажиллагаагаараа орон нутагтаа төдийгүй улс даяар алдаршсан хашир туршлагатай сайн малчид монголдоо өнгүй байсан бөгөөд тэдний мал адуулах, өсгөж үржүүлэх арга ухааныг бишрэн дээдэлж тэднээс суралцах явдал олон үе үргэлжилж байсан нь лавтай. Харин 1930-аад оны эхээр шинэ эргэлтийн бодлого хэрэгжих болсон үед буюу 1935 онд Монгол Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн дарга А.Амарын санаачлагаар бүх аймгийн хашир сайн малчдыг орон нутаг хуралдуулж түүнээс шилэн сонгосон хэсэг малчдыг 1935 оны 5 дугаар сард Улаанбаатарт урьж авчран зөвлөлгөөн хийлгэж мал аж ахуйн талаар төрөөс баримтлаж буй бодлогын тухай илтгэл сонгож улмаар тэдний арга туршлагыг яриулж малын өвчин эмгэгийг хэрхэн анагаадаг, үүдэр угсааг яаж сайжруулдаг байсан уламжлалт арга, түүний шинжлэх ухааны эмнэлэг, мал үржүүлгийн ажилтай яаж хослуулах талаар санал солилцсон нь зохих үр дүнгээ өгчээ.

1941 оны 4 дүгээр сарын 18-нд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл Намын Төв Хорооны хавсарсан хурлаас 1941 оны намар Улсын сайн малчдын зөвлөлгөөнийг Улаанбаатарт хуралдуулахаар шийдвэрлэж²⁰, уул зөвлөлгөөнийг 1941 оны 11 дүгээр сарын сүүлчээр Улаанбаатар хотод нээж Х.Чойбалсан өөрөө илтгэл тавьжээ.

Монголын эдийн засаг, соёл боловсролыг хөгжүүлэх, улс орныг батлан хамгаалахад мал аж ахуй гол үүрэгтэйг Х.Чойбалсан онцлон тэмдэглээд мал хэдий чинээ олон байх тутам ард түмний аж байдлын түвшин дээшилж улс орны хөгжлийн хурдац түргэснэ. Иймээс “Мал аж ахуйгаа хязгааргүйгээр хөгжүүлэхийн тулд ард олон түмний хувийн аж ахуйн санаачлагыг нам, засгаас бүхий л аргаар санаачилж дээшлүүлэх явдалд оршино гэжээ. Энэхүү зөвлөлгөөнд Х.Чойбалсангийн тавьсан илтгэлтэй холбогдуулан 122 хүн үг хэлж 301 хүн өөрсдийн саналаа бичгээр гаргажээ. Тус зөвлөлгөөнд оролцсон хүмүүсийн ажил хөдөлмөрийг үнэлж 459 хүнийг одон, медалиар шагнаснаас гадна бүх малчин төлөөлөгчдөд “Хамгийн сайн малчин”²¹ тэмдэг олгожээ.

²⁰ БНМАУ-ын Бага хурал, Засгийн газраас гаргасан хууль, дүрэм, тогтоолуудын эмхтгэл I, УБ, 1944, 32.

²¹ БНМАУ-ын Бага хурал, Засгийн газраас гаргасан хууль, дүрэм, тогтоолуудын эмхтгэл, I-II дэвтэр,

Үүнээс хойш ийм зөвлөлгөөн 1943, 1948 онд хоёр удаа хуралдсан байна. Эдгээр гурван зөвлөлгөөний материалаас ажиглахад нилээд сонин зүйлийг харж болно. Годруулбал, эдгээр зөвлөлгөөнд 1111 хүн оролцсоны дотор хөрөнгө чинээний хувьд буюу өмчилж буй малын тоо толгойн хувьд гол төлөв 50-иас 400 толгой малтай буюу тухайн үед дундаж аж ахуйтан хэмээх бүлэглэлд хамруулж байсан хүмүүс нийт төлөөлөгчдийн 84,3 хувь нь буюу 937 хүн байлаа. Харин 50 хүртэл малтай хүн ердөө 8-хан буюу дөнгөж 0,7% нь байлаа. 401-ээс 1000 хүртэл малтай төлөөлөгч 156 буюу 14,1 хувь, 1000-аас дээш малтай нь ердөө 9 буюу 0,8 хувь болж байв.²² Гэтэл тэр үед улсын хэмжээнд 1000 ба түүнээс дээш малтай өрх 220 гаруй байсан юм. Энэ нь тэдгээр баян малчдын дөнгөж 4 хувийг улсын сайн малчдын зөвлөлгөөнд оролцуулсан болохыг харуулж байна.

Тэр үед баян малчдыг дэмжих тухай Улсын Бага хурлын тогтоол хэрэгжиж байсан боловч тэднийг улсын сайн малчдын зөвлөлгөөнд оролцуулах талаар ер анхаарч байгаагүй нь тодорхой байна. Уг нь 1944 оны 9 дүгээр сарын 22-нд МАХН-ын Төв Хороо, Ардын Сайд нарын Зөвлөлөөс хавсарсан тогтоол гаргаж “Хувийн мал сүргийг олон мянган тоонд хүртэл өсгөж чадсан тэргүүний мал аж ахуйтан ба ардын мал аж ахуйн нэгдлүүдэд Засгийн Газраас үүрдийн дурсгалыг олгож хадгалуулах ба алдар цол шагнах тухай” тогтоол гаргасан юм. Уул тогтоолд заахдаа: “Мал өсгөхийн төлөө өөрийн үнэнч шударга хөдөлмөрийг ихээр гаргаж хувь хувийн мал сүргийг өргөн арвинаар өсгөсөн хүн нь манай оронд дурсгал гавьяат хүн мөн. Өөрийн мал сүргийг олон мянган толгойд хүргэж чадсан ардын мал аж ахуйтан, мал аж ахуйн нэгдлүүдийг сайшаан дурсгахын тул улсаас тусгайлан үнэлж, эд зүйлийг дурсгал болгон хадгалуулах хийгээд алдар цол шагнах явдлыг зүйтэй хэмээн тэмдэглэж байна”²³ гэжээ.

Уул шагналын болзол нь олон малтай айл өрхийг 1000, 5000, 10000 малтай хэмээн гурван зэрэг болгож тусгай шагнал олгох болов. Тэр шагнал нь 1000, 5000, 10000 гэсэн мөнгөн тоо, “хатан сүйх” хээ бүхий гурван бүслүүртэй саалийн агар хувин, таван хошуу малын зураг товойлгон дүрсэлсэн мөнгөн чимэглэл, тухайн аж ахуйн олонх сүргийн хээлтүүлэгч малын мөнгөн дүрс (10000 малтанд бол таван төрлийн хээлтүүлэгч малын дүрс), 6 ханатай өвч бүрээстэй гэр, хоёр хажуу дээрээ “Монгол Улсын Засгийн Газраас дурсгал болгов” гэсэн үг бүхий 12-18 чийний майхан нүүдлийн хашаа, сүүний машин, өвс хадах морин машин, тармуур зэргээс гадна 10000 малтанд 6 ханатай 6 тогто бүхий ган тулга шагнаж байх болжээ.

Ингээд 1945 оны 11 дүгээр сард Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор мянгаас дээш малтай 97 айлдуул шагналыг хүртээв. 1947 оны 7 дугаар сард 57 өрхөдуул

УБ, 1942, 37-75, 181-182.

²² Эх орны манаа, 1948-ХII-14.

²³ БНМАУ-ын Бага хурал, Засгийн газраас гаргасан хууль, дүрэм, тогтоолуудын эмхтгэл I, II дэвтэр, УБ, 1942, 87-90.

шагналыг олгож “Улсын алдарт сайн малчин” гэдэг цол хүртээжээ. Гэвч 1945-1947 онд ийнхүү шагнал хүртээсэн 154 өрхийг улсын сайн малчин хэмээн төр засгаас үнэхээр үнэлж байсан гэхэд бас ч эргэлзмээр байдаг. Яагаад гэвэл, 1948 оны 12 дугаар сард Улаанбаатарт хуралдуулсан Улсын мал аж ахуйн сайчуудын гуравдугаар зөвлөлгөөнд 1000 ба түүнээс дээш малтай 200 гаруй хүнээс ердөө тавыг оролцуулсан нь биднийг ингэж үзэхэд хүргэж байгаа юм. Ер нь 1947 оноос хойш мянган малтай өрхөд дээрх шагналыг олгохгүй арван жил өнгөрөөгөөд 1957 оны 10 дугаар сарын 17-нд МАХН-ын Төв хорооны улс төрийн товчооны 336 тоот тогтоолд Увс аймгийн Наранбулаг сумын малчин Бөөрийн Иргэл мал сүргээ түм (10000) хүргэснийг тэмдэглээд “ган тулга, таван төрлийн хээлтүүлэгч малын мөнгөн дүрс мөнгөн альбом (чимэглэл), мөнгөн бүслүүртэй хувин зэрэг зүйлээр шагнахыг Сайд нарын Зөвлөлд зөвшөөрсүгэй”²⁴ гэж заасны дагуу Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор Б.Иргэлд дээрх шагналыг хүртээжээ. Ийнхүү 1945, 1947, 1957 онд гурван удаа 155 хүндүүл шагналыг хүртээсэн байна.

Хэдийгээр 1944 оноос олон малтай айл өрхийг шагнаан урамшуулж эхэлсэн боловч улсын хэмжээгээр нийт сүргийн тоо толгойн өсөлтөд төдийлөн ахиц гарсангүй харин ч хорж цөөрч байлаа. Тухайлбал, 1944 онд 24,3 сая байсан улсын нийт мал 1948 онд 20,8 сая болж 3,5 саяар буюу 14,5 хувиар хорогдсон байна²⁵. 1944 оноос хойш 4 жил дараалан малын тоо толгой хорогдсон нь хэд хэдэн шалтгаантайн дотор ЗХУ-аас импортоор авдаг хүнсний зарим бараа тухайлбал гурил будааны хэмжээ багассан учир малыг хүнсэнд хэрэглэх нь үлэмжхэн нэмэгджээ. Мөн улсын төвлөрсөн бэлтгэлд тушаасан малын тоо үлэмжхэн нэмэгдэж байв. Жишээлбэл 1944 онд улсын нийт мал сүргийн 9,5 хувь, 1945 онд 11,0 хувь, 1946 онд 6,4 хувь, 1947 онд 11,7 хувийг төвлөрсөн хэрэгцээнд бэлтгэж байв. Түүнээс гадна 1944 онд тус улсын бүх нутгийг хамарсан их зуд болсны уршгаар 1945 онд улсын тоо бүртгэлийн дүнгээр малын тоо 20,0 сая болж 1944 оныхоос 4,3 саяар буюу 17,7 хувиар хорогдсон байна.²⁶

Монголын нам төрийн удирдагчдын зарим нь тухайлбал Х.Чойбалсан баян малчдыг дэмжиж, тэднийг шагнаж урамшуулж байх талаар бусдаасаа илүү анхаарч байсан боловч нам төрийн удирдагч бусад хүн түүнийг чухамдаа төдийлөн дэмжиж байгаагүй мэт. 1947 онд МАХН-ын XI их хурал дээр Х.Чойбалсангийн тавьсан “Намын Төв Хорооны ажлын тухай” илтгэлд “мал аж ахуй ба газар тариалан” гэсэн асуудлыг тусгайлан авч ярьсан байдаг боловч олон малтай баячуудын тухай ганц ч үг өгүүлбэр тэр илтгэлд огт байсангүй.

Түүнээс хойш 1948 оны 2 дугаар сард “Улсын мал хөдөө аж ахуйн

²⁴ НТА. Ф.4, Д-23, ХН-207, 112.

²⁵ БНМАУ-ын Хөдөө аж ахуй 50 жилд, Статистийн эмхтгэл I-р хэсэг, УБ, 1974-д буй тоог үндэслэж бодов.

²⁶ БНМАУ-ын Хөдөө аж ахуй 50 жилд. Статистийн эмхтгэл I-р хэсэг, УБ, 1974, 50.

сайчуудын гуравдугаар зөвлөлгөөн” дээр Х.Чойбалсан үг хэлж “Манай нам, засаг нь гагцхүү дунд аж ахуйтнууд ч биш, харин 500-7000-1000 буюу түүнээс дээш малтай аж ахуйтнуудыг дэмжсээр ирсэн ба одоо ч дэмжиж байна. Цаашид ч дэмжинэ. Нам, засаг нь мянган малтныг дэмжиж байгаагаар барахгүй харин ард бүрийг аль болохоор олон малтай болгохын тул зорьж ажиллаж байна”²⁷ гэжээ. Энд тэмдэглэснийг ажиглавал, нам төрөөс баян малчдыг дэмжсээр байсан мэт. Гэтэл 1949 онд БНМАУ-ын IX Их Хурал дээр Чойбалсан “Засгийн газрын ажлын тухай” тавьсан илтгэлийнхээ нилээд хэсгийг мал аж ахуйн асуудалд зориулсан боловч баян малчдын талаар ганц үг хэлсэнгүй өнгөрчээ. Тэр үед Монголын удирдах ажилтны дотор Х.Чойбалсангийн удаах суудлыг эзэлж байсан Ю.Цэдэнбал 1944-1959 онд улсын хэмжээний хэд хэдэн хурал зөвлөлгөөн дээр үг хэлж илтгэл тавьсан боловч мянган малтны тухай, хөдөөгийн баячуудын тухай ганц үг өгүүлбэр хэлээгүй байсан нь ердийн зүйл яавч биш билээ. Тухайлбал 1947 онд намын XI Их хурал дээр Ю.Цэдэнбал “БНМАУ-ын ардын аж ахуй ба соёлыг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөөний үндсэн зорилтууд” хэмээх илтгэл тавихдаа мал аж ахуйн тухай тусгайлан авч ярьсан байх боловч мянга буюутүүнээс дээш малтай баячуудын тухай огт дурдсангүй. 1948 оны 12-р сард Мал ба хөдөө аж ахуйн сайчуудын III зөвлөлгөөнийг нээж хэлсэн үг 1949 онд БНМАУ-ын IX Их хурал дээр “БНМАУ-ын сонгуулийн системийн ардчилалыг цаашид улам хөгжүүлэх тухай” илтгэлдээ ч олон малтны тухай хөндөөгүй юм. 1955 онд “БНМАУ-ын хөдөө аж ахуйн нэгдлүүдийн тэргүүний сайчуудын анхдугаар их хурал” дээр Ю.Цэдэнбал дэлгэрэнгүй үг хэлсэн байх боловч хувийн аж ахуйтны баян чинээлэг хэсгийнхний тухай “хар цагаан” дуугаралгүй өнгөрчээ.

Эд бүгдээс ажиглахад баян малчдыг онцгойлон үзэж шагнал хүртээх шийдвэр 1944 оны намар гэв гэнэт гараад ирсэн нь тун ч сонирхолтой байгаа юм. Иймд энэ талаар ганц нэг зүйлийг хэлж уншигч судлаач нартай санал бодлоо хуваалцъя гэж бодлоо. Мянга буюу түүнээс дээш малтай өрхийг онцгойлон үзэж урамшуулан шагнах болсон шийдвэр 1944 онд гэв гэнэт гарч ирсэн бөгөөд өмнө нь нам төрийн удирдах ажилтнууд энэ талаар ярьж хэлэлцэж байсан зүйл огт мэдэгдэхгүй байгаа юм. Харин баян чинээлэг малчдыг зээл, албан татвар, бэлтгэлийн бодлогоор хавчих хандлага 1940 оноос эхлэн зугуухан гүнзгийрчээ. Ер нь олон малтныг дэмжье урамшуулж шагнаж гэсэн зүйл нам улсын хэмжээний томоохон хурал зөвлөлгөөн дээр энэ талаар ярьж байсан зүйл огт байдаггүй. Тухайлбал 1932 оны зун хуралдсан БНМАУ-ын онц XVII бага хурал, түүний дараа 1934, 1940, 1949 онд хуралдсан БНМАУ-ын VII-IX их хуралд 1934-1949 онд хуралдсан БНМАУ-ын XVIII-XXXI бага хурлуудын илтгэл тогтоол, 1940-1958 онд хуралдсан МАХН-ын X-XIII Их хурал болон Намын төв хорооны удаа дараагийн бүгдхурлууд болон Намын төв хорооны Улс төрийн товчоо, засгийн

²⁷ Чойбалсан Х. *Илтгэл ба өгүүлүүд* IV боть, УБ, 1946-1951, 186.

Монголын төр ба мал сүрэг (1921-1959)

газрын хурлуудаар олон асуудал хэлэлцсэний дотор мал аж ахуйн тухай тусгайлан хэлэлцэж байсан боловч баян малчдын тухай асуудлыг ер хөндөж байгаагүй бололтой.

Хэрэв Монголын нам төр хөдөөгийн баячуудаа 10 жил тууштай дэмжсэн бол тодорхой үр дүндхүрэх байсан мэтбодогддог. Гэтэл 1944 ондХ. Чойбалсангийн саналаар баячуудыг хөхиүлэн шагнах болсон нь удалгүй “мартагдаж” эхэлсэн нь тун ч харамсалтай.

Мөн үүнтэй холбогдуулж бас нэг тэмдэглэх зүйл бол 1941, 1943, 1948 ондУлсын сайн малчдын гурван удаагийн зөвлөлгөөн дээр ч баян малчдын тухай тодорхой зүйл яриагүй байдаг. Иймээс ч Монголын нам төр, хөдөөгийн баян чинээлэг хэсгийг буюумянгаас дээш малтай өрх айлыг урамшуулдаг төр засгийн бодлого төдий л удаан үргэлжилж чадсангүй. Гэвч энэхүү шагналын үрээр мянгат малчны тоо жилээс жилд өсөж байсан нь тоон үзүүлэлтээр нотлогдож байгаа юм. 1949 онд хэвлэсэн “Животноводство МНР. Выпуск 1” хэмээх эмхтгэлийн 341-346 дахь тал, 453-465 дахь талд буй дүн бүртгэлийн мэдээг ашиглаж доорх хүснэгтийг боловсруулсан юм.

Хүснэгт 6.

	Аймаг	Он	Өрх		Мал	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Архангай	1944	=	=	=	=
		1945	=	=	=	=
		1946	1	0.0052	1018	0.1
		1947	3	0.02	3289	0.2
2	Баян-Өлгий	1944	4	0.1	5109	0.7
		1945	6	0.1	7118	0.9
		1946	9	0.1	10660	1.3
		1947	12	0.14	14241	1.9
3	Баянхонгор	1944	3	0.02	3442	0.2
		1945	1	0.01	1141	0.1
		1946	3	0.02	3140	0.2
		1947	5	0.004	5285	0.3
4	Булган	1944	9	0.1	10421	0.8
		1945	7	0.1	8296	0.6
		1946	16	0.1	18929	1.5
		1947	19	0.17	22029	2.2
5	Говь-Алтай	1944	9	0.1	10133	0.7
		1945	2	0.02	2283	0.3

3. Лонжид

		1946	3	0.03	3638	0.4
		1947	2	0.02	2275	0.2
6	Дорноговь	1944	3	0.1	3688	0.3
		1945	3	0.1	3616	0.4
		1946	6	0.1	7260	0.7
		1947	5	0.08	6174	0.6
7	Дундговь	1944	8	0.1	9080	0.9
		1945	1	0.01	1040	0.1
		1946	3	0.1	3200	0.4
		1947	8	0.1	9013	0.9
8	Завхан	1944	5	0.03	6512	0.4
		1945	4	0.02	5428	0.3
		1946	8	0.1	9157	0.6
		1947	9	0.05	10682	0.6
9	Өвөрхангай	1944	4	0.3	44.79	0.2
		1945	4	0.02	4608	0.3
		1946	7	0.04	8010	0.4
		1947	7	0.05	8278	0.5
10	Өмнөговь	1944	2	0.03	2299	0.3
		1945	3	0.05	3318	0.6
		1946	3	0.05	3556	0.6
		1947	5	0.09	9705	1.0
11	Сүхбаатар	1944	7	0.1	9768	0.9
		1945	5	0.1	6394	0.8
		1946	16	0.2	28773	3.0
		1947	19	0.2	29681	3.7
12	Сэлэнгэ	1944	=	=	=	=
		1945	=	=	=	=
		1946	=	=	=	=
		1947	=	=	=	=
13	Төв	1944	5	0.002	5828	0.2
		1945	3	0.01	3336	0.2
		1946	7	0.03	7849	0.4
		1947	8	0.03	9959	0.6
14	Увс	1944	51	0.5	74393	3.4
		1945	31	0.3	44506	2.6
		1946	47	0.4	65191	3.5

Монголын төр ба мал сүрэг (1921-1959)

		1947	56	0.5	75802	5.5
15	Ховд	1944	13	0.1	16239	0.9
		1945	10	0.1	11459	0.8
		1946	17	0.2	10436	1.4
		1947	19	0.2	23439	2.0
16	Хөвсгөл	1944	=	=	=	=
		1945	1	0.01	1033	0.1
		1946	2	0.01	2230	0.1
		1947	1	0.005	1295	0.9
17	Хэнтий	1944	8	0.1	10117	0.7
		1945	9	0.1	10920	1.1
		1946	9	0.1	11877	1.1
		1947	9	0.7	11519	1.2
18	Чойбалсан	1944	5	0.05	7102	0.5
		1945	5	0.05	7749	0.6
		1946	29	0.3	52176	3.9
		1947	33	0.3	55440	6.4
	Улсын дүн	1944	136	0.063	178610	0.73
		1945	95	0.043	122245	0.61
		1946	186	0.084	247100	1.17
		1947	220	0.98	294106	1.42

А.М. Печниковын хэвлүүлсэн эмхэтгэлээс авсан энэ хүснэгтийг харахад, 1944-1947 онд Монголын мянга буюу түүнээс дээш малтай өрхийн тоо нилээд түргэн нэмэгдэж, тэдний эзэмших малын тоо ч өсөж байсан нь дээрх хүснэгтээс тодорхой байна. Тухайлбал, 1944 онд баян малчин өрх 136 байсан нь 1946 онд 186 болж 50-иар буюу 26.9 хувиар нэмэгдэж, 1944 онд мянгат малчны нэг өрхөд дунджаар 1313 мал ногдож байсан бол 1946 онд 1328 болж 15 малаар өсчээ. 1947 онд энэ үзүүлэлт нилээд ахиж, мянгат малчин 220 болж 1944 оныхоос 84-өөр буюу 38.2 хувиар, нэг өрхөд ногдох мал 1336 болж 23 малаар нэмэгдсэн байна. Нийт сүргийн 0.73 хувь буюу 178600 мал 1944 онд мянгат малтны өмчид байсан бол 1946 онд энэ үзүүлэлт 1.17 хувь ба 247100 толгой болж, 1947 онд 1.42 хувь 294106 толгой болж, мянгат малчны тоо, мал аж ахуйд тэдний эзлэх хувь нэмэгдсээр байв. 1947 онд байсан тэдгээр 220 баян малчин өрх 1200 гаруй ядуу дунд амьжиргаатай айл өрхийн 6000-7000 орчим хүнийг тэтгэн, гэжээж байсан багцаа тооцоо гарч байгаагаас үзэхэд баян чинээлэг өрх улс орны эдийн засаг аж ахуйд чухал үүрэгтэй байсан нь тодорхой юм. Жич, 1945 онд Баргаас БНМАУ-ын Чойбалсан аймагт шилжин ирсэн нэг сумынхны дотор 1000 ба түүнээс дээш

малтай өрх 20 гаруй байсан учраас 1945 онд тус аймагт мянгат малчин 5 байсан нь 1946 онд 29, 1947 онд 34 болж нэмэгдсэн юм.

Мянган малтай аж ахуйтан бүхэн баян чинээлэг мөлжигч үл бүтэх этгээд хэмээн гадуурхаж хавчих хандлага 1947 оноос хойш сэргэсэн нь улс орны мал аж ахуйн хөгжилд нилээд сөрөг нөлөөлснийг тэмдэглэх хэрэгтэй. Тухайлбал, өөрийнхөө мал сүргээс бусдад олноор нь бэлэглэх, улсын бэлтгэлд сайн дураараар олон мал тушаах хандлага 1946 оноос нилээд түгээмэл болж байсан бололтой байдаг. Энэ талаар нь уйгагүй судалбал тодорхой тоон үзүүлэлтээр нотлон ярьж болох авч бид энэ удаа энэ талаар ямар нэгэн зүйл өгүүлээгүй юм. Үүнтэй холбогдуулж ганцхан жишээ хэлэхэд, Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын 5-р багийн ард, улсын сайн малчин бөгөөд улсын тэргүүний малчдын I, II зөвлөлгөөнд оролцож байсан Цэндийн Ойдов 1947 онд МАХН-ын Төв хороо, Засгийн газарт хүсэлт гаргаж 1947 онд тоолуулсан 1317 толгой малынхаа 1000-ыг улсдаа өгөхийг мэдэгдээд үлдэгдэл 317 толгой малаараа амь зуух бололцоотой гэдгээ бичсэн байдаг энэ мэтийн жишээ олныг дурдаж болно. Ийнхүү өөрийнхөө мал хөрөнгөнөөс улсад өргөхийг хүссэн тохиолдол зөвхөн 1940-өөд оны дунд үед гарч байгаагүй бөгөөд 1929-1932 онд зүүнтнүүд олон малтай айл өрхийг төр засгаас ад үзэж хөрөнгөтөн “феодал” мөлжигч хэмээх болсон учир жирийн малчнаас эхлээд төр засгийн зарим удирдагчид хүртэл олон хүн өөрийн мал сүргээс улсын санд өргөж байсан юм. Ингээд бодохоор баян малчид өөрийнхөө малаас уйдсандаа буюу төр засгийн сан хөмрөг ядуу зүдүү байна гэж бодсондоо бус харин аргагүйн эрхэнд малаасаа хагацах “ухаан сийлсэн” үедээ малаа өргөдөг байсан бололтой. 1941 оноос эхлэн улсын бэлтгэлийн албан журмын систем тогтож мах, ноос, сүү, өөх тосны ногдол биелүүлээгүй хүн төрийн хууль зөрчсөн гэмтэн болж, ял хэрэгт цөөнгүй татагдаж байсантай холбоотойгоор малаа бусдад буюу улсад өгөх болжээ. Ер нь ч 1941 оноос хойш өөрийн мал сүргээ “ялтай мал”, “улсын мал”, “миний юм биш” гэсэн хандлага нилээд газар авч 1957 оноос хойш малыг зарж борлуулах, бусдад бэлэглэх тохиолдол түгээмэл болсон нь тухайн үеийн төр засгаас баян малчдыг болон хөдөө аж ахуйн нэгдэлд элсээгүй айл өрхийг санхүү зээл, албан татвар, улсын бэлтгэлийн бодлогоор илэрхий хавчих болсонтой шууд холбоотой билээ. Ийнхүү нам төрийн алдаатай бодлогын уршгаар улсын хэмжээгээ мал сүргийн өсөлт тогтворгүй болж, олон жил үргэлжилсэн билээ.

Хэрэв баячуудыг тэтгэх бодлого тасралтгүй 10-15 жил үргэлжилсэн бол тус улсын эдийн засгийн үндэс болсон мал сүргийн өсөлтөд тодорхой тус дөхөм болох байсан боловуу гэж бодогддог. Гэтэл 1948 оноос эхлэн олон малтай өрх, аж ахуйтныг адшоо үзсээр 1959 онд бүх нийтээр нь албадан хоршоолож “санаа амарсан” нь Монголын төр засгийн бодлогод гарсан том алдаа байлаа. Монголын баян малчид бол суурьшмал орны баян тариачид, хувийн үйлдвэрийн эзэдтэй адил юм бүхэн дээр “гар татдаг” “ясны чанга” хүмүүс байгаагүй болохоор баячуудын

урт хормой, уужим суганд багтаж амиа хоохойлж, ам бүлээ тэжээдэг ядуу зүдүү хүмүүс олон байсан бөгөөд тэдний зарим нь буянтай хүний хаялгаар хөл дээрээ босож аймаг улсад алдаршсан сайн малчид болж байсныг ч үгүйсгэх учиргүй билээ.

Бас нэгэн зүйлийг хэлэхэд Монголын баян малчид бол мал малах уламжлалт арга ухаанд сайтар суралцсан, маш ажилч хичээнгүй, мал адгуулах, хөдөлмөр зохион байгуулах, бэлчээр усыг сонгох, мал үржүүлгийн талаар гойдмэдлэгтэй залхуурахыг “мэддэггүй”, цаг агаарын байдлыг ч урьдчилан төсөөлдөг, малын янз бүрийн өвчин эмгэгийг анагаах талаараа ч арга туршлагатай хүмүүс байсан юм. Тиймээс ч тэдний мал сүрэг, тариа будаа мэт үржиж өсөж байлаа.

Олны дунд янз бүрийн хүн байх нь зүй болохоор Монголын баян малчдын дотор ганц нэг нь наймаа худалдаагаар хөлжиж бэлжсэн байхыг үгүйсгэх аргагүй билээ. Мөн өндөр шагнал хүртэхийн тулд ах дүү хамаатан садангийнхаа малыг өөрийнхөө дансанд шилжүүлэн тоолуулж байсан ганц нэг “баян малчин” байсныг нийтэд нь хамруулан нялзааж үл болох нь тодорхой.

8. Зарц нар, мал сүрэг

Манай улсын мал бүхий иргэдийг малчин өрх, ардын хувийн аж ахуйтан хэмээн төрийн албан ёсны шийдвэр, судлаачдын зохиол бүтээлд чухам хэдий үеэс ингэж нэрлэх болсон нь төдий л тодорхойгүй аж. Харин 1924 оноос эхлэн төрийн шийдвэрт мал бүхий өрхийг ядуу, дунд, чинээлэг, мөлжимтгий хэмээн хэд хэд ангилах ба малын тоог (бод буюу толгойн тоогоор) гол шалгуур болгон үзэж байжээ.

Зарим баримт бичиг болон ихэнх судлаачийн саналаар бол 300-гаас дээш толгой малтай аж ахуйтныг мөлжимтгий этгээд хэмээн үзэж байжээ. Зарим судлаач 300-500 толгой малтай айл өрхийг дунд аж ахуйтай гэж үзэж байсан. Гэтэл олон малтай аж ахуйтан бүхэн бусдын хүч хөдөлмөрийг ашиглаж мөлжиж байсан гэвэл үнэмшил багатай. Яагаад гэвэл мал сүрэг олонтой айл өрх бүхэн бусдын хөдөлмөрийг завших ашиглах нь зайлшгүй биш юм. Тодруулбал баян айл өрх олон ам бүлтэй, ялангуяа мал адуулах чадвар бүхий хүн хүрэлцээтэй байвал тэднийд ажиллах хүчнийг буюу зарц нарыг хөлслөх эрэлт хэрэгцээ гарахгүй нь тодорхой. Мөн түүнээс гадна бод (адуу, гэмээ, үхэр) голдуу олон малтай ямар ч айлд ажиллах хүчин харьцангуй бага шаардагддаг байлаа. Ийм учраас ардын аж ахуйтныг ангилахдаа зөвхөн төлж байсан татвар, мал сүргийнх нь тоо толгойг гол шалгуур болгон ядуу, дунд, чинээлэг, мөлжимтгий хэмээн зааглах нь учир дутагдалтай юм. Өрх гэрийнхнийхээ хүчээр малаа адуулахад хүчин хүрэлцэхгүй тийм аж ахуйтан, хувийн мал сүргээ алдаж осолдуулахгүйн тулд арга буюу бусдыг хөлслөн ажиллуулах шаардлагатай болдог байлаа. Энэ бол гагцхүү баяжих

зорилготой шууд холбоотой зүйл биш билээ. Янз бүрийн сурвалжаас үзэхэд зарц нарын хөдөлмөрийг зөвхөн олон малтай баян аж ахуйтан ашиглаж байсангүй, зарим дунд аж ахуйтан ч зарцтай байсан тохиолдол дайралддаг. 1921-1928 оны дунд үе хүртэлх хугацаанд тус улсын эдийн засгийн нэг чухал хэсэг болсон ардын аж ахуйтны мал сүргийн тогтвортой өсөлтийг хангахын тулд хөдөө дэх хөдөлмөрийн илүүдэл нөөцийг аль болохоор ашиглахад тус дэмжлэг үзүүлэхэд чиглэж байлаа. Үүнээс уламжлан ямар ч аж ахуйтан зохих хууль дүрмийн дагуу зарц ажиллуулах эрхтэй байв. 1925 оноос дагаж нийтлүүлсэн хүчин үнэлэгчдийн хуулиар ямар ч хүн өөрийн аж ахуйдаа зарц, хөлсний ажилчин хэрэглэж болохыг зөвшөөрсөн байдаг. Хэдийвээр 1924 онд БНМАУ-ын Үндсэн хуульд зааснаар хувийн аж ахуйдаа хөлсний хөдөлмөр ашиглагчдын улс төрийн эрхийг хасахаар заасан боловч олон малтай баян айл өрхийн зарим нь өөрийн хүчээр малаа адуулах хүчин хүрэлцэхгүйн улмаас арга буюу бусдыг зарцалж байлаа. Гэтэл төр засаг зарцтай өрх бүхнийг мөлжигч этгээдхэмээн адүзэж байсан бөгөөдшинэ эргэлтийн бодлогын үед ч ийм байдал мөн л хэвээр үргэлжилж байв. Жишээ нь 1932 онг намар батлагдсан “Мал, тариалангийн албан татварын тухай” хуульд зааснаар тухайн өрх зарцтай бол жилийн бүх орлогынх нь 50 хувийг, хэрэв сонгуулийн эрхээ хасуулсан бол 75 хувийг татварыг хурааж байхаар заасан байдаг.

Хэдийгээр төр засаг баян чинээлэг айл өрх зарцтай байхыг төдий л дэмжихгүй байсан боловч арга буюу зарцтай байж тэдний хүчээр олон малтай болж хөлжиж биежсэн айл өрх цөөнгүй байсан билээ. Бас нэг анхаарууштай зүйл бол зарцтай өрх бүхэн баян байгаагүйтэй адил зарц нартаа хөдөлмөрийнх нь хөлсийг хангалттай өгдөг баячууд цөөнгүй байсан боловч өчүүхэн бага хөлс өгдөг буюу зөвхөн хооллож ундлахаас төдий л хэтэрдэггүй баячууд ч байсныг бас үгүйсгэх учиргүй.

Бидний санахад, хөлсний хөдөлмөр дээр хувийн аж ахуйгаа зохион байгуулна гэдэг бол их бага ямар нэгэн хэмжээгээр бусдын хөдөлмөрийг ашиглах замаар ашиг орлогоо нэмэгдүүлж байсан нь тодорхой. Зарц нарын ихэнх нь хэдийгээр гэрээ, хэлэлцээр байгуулан ажиллах боловч тэдний авдаг хөлс шан нь харьцангуй бага хэмжээтэй байлаа. Зарим үед зөвхөн ганц хоёр бод, дээлийн өнгө даавуу (даалимба дурдан төдийхөн) эсвэл саалийн хэд гурван үнээ мал түр хугацаагаар ашиглуулснаар зарцын хөлс төлөгдөж байсан тохиолдол ховор биш байлаа.

Ийм байдлыг нь хэт дөвийлгөж зарц бүхэн “боолын хөдөлмөр” эрхэлж баян айлын хоолны шавхруугаар гэдсээ тэжээж байсан мэтээр үздэг явдал 1929-1959 он хүртэл түгээмэл байсан юм. Чухамдаа бол зарц нарын цөөн зарим нь багахан хөлс шан авдаг байсан боловч тэд өлсгөлөн ховроос болж амиа алдаж байсангүй, баян хүнд зарцлагдсаныхаа хүчээр амь зууж байсан төдийгүй зарим айлын зарц нар хөлсөнд авсан хэд гурван малаа үржүүлсээр дунд аж ахуйтны

эгнээнд шилжиж байсныг ч бас тэмдэглэх хэрэгтэй.

Тэр үед зарим сэтгүүлчид бодит байдлыг хэтэрхий гуйвуулж бусдын худал үгийг үнэн болгон бичсэн зүйл ч бас байсан бололтой юм. Жишээлбэл, Г.Дэлэг сэтгүүлч 1954 оны 2-р сарын 22-нд “Үнэн” сонинд өгүүлэл бичиж Баян-Өлгий аймагт 242, Ховдод 172, Хөвсгөлд 106, Увсад 40 шахам, Сүхбаатарт 40 орчим зарц, байгааг дурдаад Увс аймгийн Наранбулаг 4-р багийн Бөөрийн Иргэл 10000 малтай 37 өрх айлын 80 орчим хүн зарцалж байна хэмээн хэвлүүлсэн байна. Гэтэл тэрхүү нийтлэлд нэр нь тэмдэглэгдсэн Увс аймгийн Наранбулаг сумын Цэмбэлийн хоёр мянган малаас хамжилцаж айлсан сууж байсан зарц Мэгрэн уул өгүүлэлдогт худал зүйл хэлсэн байна. Би Цэмбэл аругайн тэмээг дагнан малладаг хангалттай хөлс авдаг. Гэтэл намайг ердөө ганц тэмээ авдаг хэмээн гүтгэжээ гэж аймгийн шүүхэд заргалдаж байжээ. Харин Б.Иргэлийн төллөх хонь маллаж байсан хоёр ч хүн хариулж байсан малаа бэлчээрт нь хаяад шууд Иргэлийн гэрт очиж хөлсөө нэмж өг хэмээн шаардаж элдвээр аашилж загнаж байсан гэдэг. Мөн дээрх нийтлэлээс хойш мөн оны 3-р сарын 18-нд Сүхбаатар аймгийн Халзан сумын 1-р багийн ард М.Доной “Үнэн” сонинд захидал хэвлүүлж Г.Дэлэг “миний нүдийг нээж өглөө. Манай Халзан сумын 30 шахам айл баян Дандарын Шаравдоржийнд зарцлагдаж малын сүүнээс өөр юу ч авдаггүй. Тэрийг нь сүүг зун л саадаг юм даа. Миний бие 1950 онд Шаравдоржийнхоос 15 эм хонь авч 3 жил маллаад 97 болгож өгсөн билээ” гэжээ. Мөн Лувсангийн Соо гэгч хүн бичихдээ: Би 1952 онд Шаравдоржийнхоос 25 эм хонь авч одоо 118 болов. Хонь бүрээс 1,5 кг ноос авч өгдөг гэжээ. Мөн Я.Санжаа гэгч бичихдээ би 1948 онд Шаравдоржоос 15 эм хонь авч одоо 130 болоод байна гэжээ. Энд бичсэн зүйлээс үзэхэд зарц нарын амьдрал тийм ч сайнгүй байсан нь үнэн бололтой. Гэхдээ тэд өөрийнхөө хариулж буй малын ашиг шимээр амь зуудаг байсан нь тодорхой юм. Харин 15-хан эм хонийг 1948-1954 онд маллаад 130 болгож өгсөн гэдэгт эргэлзэх зүйлгүй юм. Увс аймгийн Өлгий сумын харьяат Идэшийн Цунцал гэгч 1987 онд ярихдаа тэр үед чинь хонийг жилд хоёр төллүүлдэг байсан юм гэж яриснаас үзэхэд Сүхбаатар аймагт ч мөн л хонийг жилд хоёр төллүүлдэг байсан бололтой. Зарц нарын зарим нь ялангуяа ганц бие зарц нар зарагдаж байгаа айлдаа сууж хоол унднаас нь гэрийн эзэдтэй адил идэж ууж байсан боловч тусгайлан хөлс авна гэж заргалдах нь ч байжээ. Жишээ нь: Говь-Алтай аймгийн Цогт сумын 4-р багийн Бадарчийнд Цээл сумын Хажид гэгч гурван жил зарцлагдаад зөвхөн хуучин тэрлэг нэгийг авсан гэж 1954 оны 2-р сарын 22-нд “Үнэн” сонинд бичсэн байв. Ийнхүү төвийн хэвлэлд Г.Дэлэг, С.Дашдэндэв зэрэг хүмүүсийн бичсэн нийтлэлийн дараа зарц нар болон зарцтай баячуудын аль аль нь урьдынхаасаа нилээд өөрчлөгдөж өгч авдаг хөлс нь нэмэгдэж байсны сацуу зарим зарц “эзнийхээ” малыг бэлчээрт орхиод өөр сум багийн нутаг руухэсч явснаас болж мал осолдсон тохиолдол 1954 оны 4,5-р сард Ховдын Үенч, Алтай, Увсын Наранбулаг, Баян-Өлгий Дэлүүн

сумдад нэг бус удаа гарч байсан гэнэ.

Түүнээс гадна олон малтай зарим баячууд “төр засгаас биднийг хэдэн жилийн өмнө одон тэмдэг, мөнгөн мал, агар хувингаар шагнадаг байсан юмсан. Гэтэл маршал минь талийгч болсноос хойш манийг нэг нүдээр үзэх хүнгүй боллоо” хэмээн сэтгэл санааны дарамтадорж, улмаар мал сүргээ ялын эзэн хэмээн үзэн ядаж, үрэн таран хийх тохиолдол ч гарч болзошгүй байжээ. Гэтэл 1954 оны хавраас улсын бэлтгэл, албан татварын журамд өөрчлөлт орж, ард түмний сэтгэлийг сэргээсэн юм гэж 1987 онд Увс аймгийн Цэрэвийн Доной, Долчийн Нянгар, Күүкээгийн Ишгэн зэрэг 70 гаруй насны хэд хэдэн хүн З. Лонжид над дурсан ярьж байлаа. Мөн зарц нар яагаад урьд нь ядуурч хоосорч байв гэдгийг ч бас эргэцүүлэх ёстой. Бодоход тэдний зарим нь хөндлөнгийн хүчин зүйлээс шалтгаалж ядуурсан байж болно. Харин зарим нь өөрөөсөө буюу унхиагүйгээсээ болж “хувхайрсан” байхыг үгүйсгэх аргагүй. Гэтэл зарцын хөдөлмөрийн үр шимээр бий болсон баялаг нь эзэн хүнийхээ хөрөнгийг тодорхой хэмжээгээр арвижуулж байв. Дунд аж ахуйтан өрх хүн зарцалснаар хэдий хир хөрөнгө хуримтлуулав гэдгийг өнөөдөр олж харах тийм лавтай сурвалж алга, нөгөө талаар зарцтай байсан дунд аж ахуйтан мал нь өссөөр чинээлэг буюу мөлжигч аж ахуйтан болсныг нотлох тийм зүйл ч ховор байна. Харин ийм байдлыг шууд буюу дам нотолгоо болгон тэдний зарц нарын хүч хөдөлмөр ашиглаж байсныг ор тас үгүйсгэх буюу үл ялих зүйл хэмээн үл тоомсорлох явдал байж болохгүй нь мэдээж. Түүнээс гадна амины аж ахуйдаа бусдын хүчин туслалцаа авах, хувийн аж ахуйгаа зарц нарын хүчээр зохион байгуулах нь чанарын ялгаа бүхий хоёр өөр зүйл гэдгийг бодолцох ёстой. Манай хөдөөгийн хүн амын нэг хэсэг болж байсан зарц нарын талаар нам, төрөөс явуулсан бодлогын асуудлыг түүхч Л.Бат-Очир, Л.М.Гатауллина зэрэг хэд хэдэн судлаачид хөндөн үзэж байв. Ер нь зарц нарын тухай судалгааг тусгайлан шинжих шаардлагатай.

Монголын төр 1921 оноос эхлээд ардын аж ахуйтныг нийтээр нь хоршоолж дуусах хүртэл зарц нарын талаар нилээд чанга бодлого баримталж 1925 онд батлагдсан хүчин үнэлэхүйн тухай хууль, 1932 онд Сайд нарын зөвлөлөөс баталсан мал аж ахуй ба газар тариаланд хөлсний хөдөдмөр хэрэглэх тухай түр дүрэм зэрэгт зарц нарын эрх ашгийг тууштай хамгаалсан заалт оруулж түүнийг мөрдөн хэрэгжүүлж байв. Дээрх хууль эрхийн актад заасан ёсоор зарц нар тэднийг ажиллуулагч аж ахуйтан хоорондоо заавал аман болон бичгийн гэрээ байгуулж сумын захиргаанд бүртгүүлэх ёстой байв. Зарц нарт төлөх хөлсний доод хэмжээг хуульчлан тогтоохдоо аж ахуйтны бүлэг тус бүрд харилцан адилгүй төлөвлөжээ. Жишээлбэл, дунд аж ахуйтан 300 хүртэл малтай гэж бүртгэгдсэн өрх бол сар тутам нэг зарцад 15 төгрөг, чинээлэг өрх бол 20 төгрөг, феодалын аж ахуй бол 30 төгрөгийн хөлс төлж хоол ундаа мал, орон байраар хангаж хөдөлмөр хамгааллыг нь бүрэн хариуцаж хөдөлмөрийн чадвараа түр алдвал олгох ёстой хөлсийг 100

хувь төлж эмнэлгийн шаардлагатай тусламж үзүүлнэ гэж заажээ.

Гэвч цөөн бус баячууд орон нутгийн засаг захиргааны зарим ажилтныг сул талыг ашиглан улсын хуулиар тогтоосон зарц нарын хөдөлмөрийн нөхцлийг зөрчих нь олонтоо байжээ.

9. Зарц байсан хүмүүсийн хууч яриа

Түүхийн судалгаанд бичгийн сурвалжаас гадна хууч яриа буюу аман мэдээ чухал хэрэглэгдэхүүн болдог учир Увс, Ховд аймгийн ганц нэг хүний яриаг сонирхуулья. Олон малтай баян айлууд хаврын идажлын үед зарц нараа хоногт 14-18 цаг хүртэл өөрөөр хэлбэл, “хоёр нарны хооронд” ажиллуулаад илүү нэмэгдэл хөлс огтхон ч өгөхгүйгээр үл барам зарим тохиолдолд, төлбөл зохих хөлсийг нь бүрэн олгохгүй байсныг тухайн үед зарц явсан олон хүн ярьж байна. Жишээлбэл, Увс аймгийн нэг айлд 36 жил бүх гэр бүлээрээ зарцлагдсан Б. Туз гэдэг өвгөн 1986 онд бидэнд ярихдаа хавар тариа тарих, намар тариа хурааж дуусах хооронд 5 сар гаруй хугацаанд ялангуяа хавар газар хагалж үр суулгахын өмнө ба дараа нь тогтмол хугацаанд шөнийн цагаар газар услах, намар тариа хурааж цайруулж бэлэн болсон тариаг уурхайдаваачиж хадгалах, дараа нь эзний хэрэгцээнээс илүү гарсан тариаг зарж борлуулахад нь хүртэл хүчин зүтгээд авдаг хөлс нь тун ч чамлалттай байсан тухай өгүүлж байв. Туз болон бусад хүмүүсийн хэлж байгаагаас үзэхэд хавар мал төллүүлсний дараа 10-15 хургатай хонь авч 2 сар сааж сүүгий нь ашиглана, намар идэшний 2-3 хөгшин эм ямаа, нэг хөгшин эм хонь юмуу өвчтэй төлөг, ганц даалимба 1-2 улаан тамхи л бүх жилийн хөлс болдог байжээ. Хэрэв хуульд заасан хэмжээгээр хөлсөө авна гэж зарга үүсгэх аваас ихэнх тохиолдолд нэг удаа зохих хөлсөө аваад л тухайн айлаас явах болдог байжээ. Хөлсийг нь төлсний дараа эзэн хүн, түүний гэр бүлийнхэн зарцдаа хандаж: “Бид хэл амтай хүнээр ажлаа хийлгэхгүй. Одоо та аргаа бодно биз дээ. Манайх зарцлах хүнээ олчихлоо” гэж хэлдэг байсан гэнэ. Нэгэнт ажилгүй болсон зарц хүн өөр айлд очиж ажиллая гэвч хэрэв түүнийг “хүн муутай” гэх зэргээр зарим хүмүүс муучлан ярих явдал дэлгэрсэн байвал тэр зарцдад ажил олдох нь багагүй түвэгтэй байжээ. Ингээд ажилгүй болсон зарц хүн нутгаасаа алс явж тохирсон ажил олбё гэвч амьдралын элдэв бэрхшээлд автаад чадахгүй тохиолдол цөөнгүй байсан тухай мэдэх хүмүүс ярьж байна. Харин 1940-өөд оноос эхлэн уурхай, үйлдвэрт болон бусад салбарт ажилчдыг олноор нь элсүүлэх болсноор зарц байсан хүмүүсийн зарим нь уурхай улс, хоршооллын үйлдвэрт ажилчин болж байжээ. Тийм хүмүүсийн дотор хожим хойноо улс орон даяар алдаршсан хөдөлмөрийн сайчууд олон төрсөн байна. Жишээлбэл, алдарт уурхайчин БНМАУ-ын хөдөлмөрийн баатар ах дүү Ж. Отгонцагаан, Ж. Батлай зэрэг нилээд хүнийг нэрлэж болно. Мөн зарц байснаа сургуульд суралцаж цэргийн алба хааж эрдэмтэн, цэргийн зүтгэлтэн болсон хүн цөөнгүй байдаг ажээ.

1987 онд Ховд аймгийн Булган сумын уугуул Аюушийн Буян (72 настай) багаасаа эхлээд 1959 оны хавар хүртэл айлын зарц байсан тухайгаа ярихдаа айлын хонь хариулаад сард нэг төлөг авдаг. 30 бог зун саадаг. Манайх айлын мал хариулна намарт эсгийг нь хийдэг байлаа. Эсгий хийхэд мал хариулахаас илүү цаг их авдаг. Ажлаа хир зэрэг хийсэн нь тэр дороо мэдэгддэг. Манай Булган суманд эсгийг хоёр янзаар хийдэг байлаа. Нэгдүгээрт эх эсгийгээр ноосоо зулж хийдэг. Хоёрдугаарт сүлжсэн дэрсэн дээр ноосоо зулж хасаг аргаар хийдэг байсан. 100 жин ноос (нэг жин=600гр) ноос 4-5 эсгий болно. Хөлс нь нэг жилд 10 жин ноос эсвэл 5 жин хүрнэ. Эсгийг хавар, намар хоёр удаа хийнэ. Хаварт уртын ноосоор намарт ахар ноосоор хийнэ. Эсгий хийхэд хоол унд сайн өгдөг боловч 4-5 өдөр яг сууж хийдэг болохоор мал хариулахаас хэцүү. Харин хир зэрэг хийсэн нь хүний нүдний өмнө болохоор сайхан байдаг. Ноос савахаас эхлээд эсгийг татах хүртэл 4-5 дамжлага ажил байдаг гэж яриу. Мөн сумын Батын Ишгэн (75 настай) 21-тэйгээсээ Хөх гэдэг айлын мал хариулсан хөлс нь сард нэг ямаа байлаа. Өвлийн эхэн сард бол идэшний сайн бог нэгийг өгдөг. Зарц нар нь нүүхэд ачлагын шар өгдөг байжээ. Булган суманд олон малтай ам бүл цөөнтэй боловч зарц авдаггүй хэд хэдэн айл байсан гэнэ. Тэдний нэг нь Ятабайн Жамцуу гэдэг мянга хол давсан малтай айл байж, тэднийх хүн зарцалж байгаагүй гэнэ. Жамцуу сайн малчны анхдугаар зөвлөлгөөнд оролцоход нь Маршал мөнгөн аяга бэлэглэснийг сүүлд нь сургуулийн багш Хараадайн Дорж худалдаж авч билээ гэж 77 настай торгууд Ишжамба яриу.

Жамбын буюу Буусайн Баяр гэдэг хүн 1932-1933 онд Луусайн Хожиг гэдэг айлын үхэр маллажээ. Хоёр хавар өглөөнөөс үд хүртэл 10 хэдэн хоногийн турш долоон тагтны тарианы газар хагалдаг. Нэг тагт газар 0,5-1,0 га-тай тэнцдэг байсан байх, би энийг сайн мэдэхгүй дээ. Хожигийн анжисны шарнууд өөрсдөө явж сурсан байдаг болохоор хөтлөх хүн хэрэггүй. “Зөвхөн нэг хүн шарнуудаа чиглүүлээд үрээ цацаад л явдаг. Тариа тарьж дуусахад 2 лан эсвэл хургатай хонь нэг мал хариулахад сард нэг охин төлөг өгдөг тогтсон жишиг байлаа. Манай суманд айлын мал маллаж тариа тарьдаг зарц нар олон байсан тэдний ихэнх нь сүүлдээ овоо малжсан даа” гэв.

Сэмээн Баатар гэх хүн баян Ба-гийн 1500 малыг самгантайгаа хоёул 1945 онд Хавтаг Байтагт таван бүтэн сар хариулж гунжин гүү нэгийг авсан гэнэ. Баян Ба бол ажил сайтай, хүнийг зарж ч чаддаг хэн ч чамлахааргүй хөлс өгдөг тэгэхдээ хэд хэдэн зүйл амлаад за чи аль нэгийг нь сонго гэдэг байжээ. Тиймээс Баатарыг 5 сар зарцлаад, “За чи төллөх дөрвөн бог (2 хонь, 2 ямаа), нэг гунжин гүүний аль нэгийг сонгож ав” гэсэн гэнэ. Тэгээд Баатар гунжин гүүг нь авъя гэжээ. Харин өгөх малаа баян Ба өөрөө сонгож өгдөг боловч нэг их сайн биш боловч тийм ч муу биш дунд зэргийн мал өгдөг байжээ. Тэр нутгийнхан баян Ба-гийн малыг хариулах тун дуртай байсан гэнэ.

Монголын уламжлалаар бол нэн эртнээс эхлээд мал малын захтай ам бүл цөөн айл өрхүүд хүн зарцалж амьжиргаа тааруу айл өрх, ганц бие хүнийг ам бүлээ тэжээх “бор ходоодоо борлуулахад” нь тус дөхөм болдог болж. Ийм байдал 1959 оны эцэс хүртэл Монгол улсын хэмжээнд түгээмэл зүйл байлаа. Харин 1929 оноос эхлэн “зүүнтнүүд тэнхээ мэдэж довтлох болсон” (Б.Ринчен) тэр үед зарц нарын эрх ашгийг нам, төрөөс дээд зэргээр хамгаалах тусгай бодлого хэрэгжүүлсэн юм. Тэгэхдээ юуны өмнө “малчин зарц нарын эвлэл” гэгчийг байгуулж эхлээд өндөр албан тушаалтнуудад тус эвлэлийн даргыг хавсаргаж байсан бол 1931 онд Заяат гэгчийг томилжээ.²⁸ Тус эвлэл зарц нарыг бүртгэжээ. Гэвч баг, сум, аймгуудаас авсан мэдээгээ нэгтгээгүй бололтой. Үнэн сонины 1931 оны 165-рт буй мэдээгээр бол 1930 онд 12000 зарц, 1931 онд 16000 зарц байж. Гэтэл 1932 онд улсын хэмжээгээр 20000 зарц байхад МҮЭ-ийн гишүүд ердөө 1000 хүрэхгүй шахам байна²⁹ гэж Намын Төв Хороо Хянан Байцаах Төв Комиссын хамтарсан хурлын илтгэлд цохон тэмдэглэжээ.

ШЭБ эхэлсний дараа ч төр засаг зарц нарын талаар анхаарч тэднийг янз бүрийн хурал зөвлөлгөөнд оролцуулах болжээ. 1934 онд Улсын 7-р их хуралд 19 Зарц төлөөлөгчөөр сонгогдсон бол 1940 онд 78 зарц Улсын 8-р их хуралд оролцуулжээ.³⁰ Бүрэн бус мэдээгээр 1935 онд 10 аймагт 1021 зарц бүртгэгдсэний 187 нь 1-3 сарын хугацаатай бусад нь бсараас дээш хугацаатайг гэрээ байгуулсан байжээ.³¹

Үүний дараа 1936 оны 10-р сард гаргасан мэдээгээр бол 1503 зарц байсны 864 нь гэрээ байгуулан ажиллаж байгааг 1936 оны эцсээр хуралдан “МҮЭ-ийн аймаг, хотын товчоодын дарга нарын өргөн зөвлөлгөөний хурал”-ын илтгэлийн 9 дэх талд Улсын хэмжээний бүх зарц нарын тухай мэдээг 6 үзүүлэлт бүхий тусгай хүснэгтээр тодорхойлсныг дор сийрүүлж сонирхуулья.

²⁸ НТА, 4-4-41, 81-82.

²⁹ Намын төв хороо ба Төв хянан байцаах комиссын хамтарсан онц бүгд хурлын илтгэл ба тогтоолууд, УБ, 1932, 30.

³⁰ Цапкин Н.В. О некоторых вопросах социально-экономического развития МНР, *Современная Монголия*, 1940, №1, 38.

³¹ МҮЭ-ийн аймаг, хотын товчоодын дарга нарын өргөн зөвлөлгөөний илтгэлүүд ба тогтоол, УБ, 1935, 114.

3. Лонжид

Хүснэгт 7. Зарц нарын тухай мэдээ

№	Аймаг	Бүртгэгдсэн бүх зарц	Гэрээ байгуулсан	Зарц нарын хурал хэдэн удаа хуралдуулсан	Хэдэн зарц оролцсон	Бичиг үсэг сурч буй хэд	Үйлдвэрчний эвлэлийн гишүүн болсон хэд
1	Архангай	130	90	5	50	15	6
2	Ховд	172	138	13	153	9	16
3	Хэнтий	75	45	-	-	12	2
4	Завхан	171	134	3	66	25	3
5	Өвөрхангай	34	30	-	-	6	1
6	Сэлэнгэ	49	36	6	38	8	7
7	Увс	146	110	3	19	-	1
8	Дорнод	56	32	1	62	18	-
9	Хөвсгөл	97	84	2	14	11	5
10	Төв	547	165	1	15	7	129
11	Өмнөговь	18	-	-	-	-	-
12	Дорноговь	8	-	-	-	-	-
	Бүгд	1503	864	33	417	111	170

Сурвалж: МҮЭ-ийн аймаг, хотын товчоодын дарга нарын өргөн зөвлөлгөөний илтгэлүүд ба тогтоол, УБ, 1937.

1937 онд хуралдсан МҮЭ-ийн аймаг, хотын товчоодын дарга нарын өргөн зөвлөлгөөнд тавьсан илтгэлд буй эдгээр үзүүлтээс олон гаргалгаа хийж болох авч энэ удаа түр орхив. 1938 онд МҮЭ-ээс бүртгэгдсэн зарц нар 3328 гэж мэдээлсэн баримт байна.³² Энэ нь өмнөх 1936 оныхоос 1825-аар олон байна. Эдгээр зарц нарын 1568 нь гэрээ байгуулж байжээ. Зарц нарын тоо хоёрхон жилийн дотор ийнхүү нэмэгдсэний учир бол өмнө нь бүртгүүлээгүй хүмүүс шинээр бүртгүүлсэнтэй холбоотой байх. 1951 оны мэдээгээр бол 3335 зарц³³ байсан бол 1955 оны 1-р сард 2480 зарц байна хэмээн МҮЭ-ийн төв зөвлөлөөс МАХН-ын Төв хороонд мэдээлжээ.³⁴ Зарц нарын тухай 1921-1950-иад оны эцэс хүртэл төр засгаас чухам ямар бодлого явуулсан юм бэ? гэдгийг нэхэн судалсан бүтээл тун ховор ажээ. Ямар ч атугай 1929 он буюу зүүнтний үеэс малчин зарц нарын эрх ашгийг хамгаалах тухай нилээд сүржин ажил эхэлж урьд өмнө нь хэний ч анхааралд өртөөгүй зарим зүйлийг сэдэж хэрэгжүүлсэн нь эерэг зүйл байсныг

³² НТА 4-6-216, 1.

³³ МҮЭ-ийн их хурал, төв зөвлөлийн бүгд хурлуудын илтгэл, тогтоолууд, УБ, 1962, 50.

³⁴ НТА. 1-4-36, 26 (1980 оны шифр).

үгүйсгэх учиргүй билээ. Тухайлбал, 1930 оноос эхлээд зарц нарыг 7 хоногт 1 өдөр бүтэн амрааж хөлсийг нь олгуулж байх мөн жил бүрийн 10-р сарын 16-наас дараа жилийн 4-р сарын 16 хүртэлх хугацаанд 12-оос дээш настай зарц нарт нэг сард 10-аас доошгүй Ү-ийн хөлс өгнө. 4-р сарын 16-наас 10-р сарын 16 хүртэлх хугацаанд энэ насны хүмүүст сар тутам 6-аас доошгүй Ү-ийн хөлс олгох, 6 сар хүртэл ажиллавал 14 хоногийн цалинтай амралт олгоно, 6 сараас дээш хугацаатай ажиллавал 1 сараас доошгүй хугацааны цалинтай амралт олгоно”³⁵ хэмээн шийдвэрлэж байжээ. Гэвч яг энэ ёсоор цалин, амралт олгож байгаагүй бололтой мэдээ байдаг. Харин 1941 оны 2-р сард баталсан Хөдөлмөрийн хуульд зааснаар бол 15-аас доош насны хүүхдийг хөлсөөр ажиллуулахыг хориглосныг³⁶ 1944 он хүртэл зохих ёсоор дагаж мөрдөж байсан бололтой мэдээ цөөнгүй бий.

Ахмад настны яриа, хэвлэлийн зарим мэдээ, сурвалжаас үзэхэд зарц бүхэн хоосон ядуу хүмүүс байсангүй, дунд зэргийн аж ахуйтны зарим хэсэг нь янз бүрийн хуагцаагаар бусдад зарцлагдан зохих хөлс шан авч амь зуулгадаа нэмэрлэдэг байжээ. Зарц нарын тухай дүрэм, зааврыг ажиглахад гагцхүү ядуу хоосон хүн л бусдад зарцлагдаж болно гэсэн заалт байхгүй юм. Ер нь ингэж хориглож болох ч үгүй байсан нь мэдээж. Хувийн мал аж ахуй эрхлэгчдийн дунд буй хөдөлмөрийн нөөцийг зохистойгоор ашиглах, мөн ажиллах хүч нь хүрэлцэхгүй өрхийг хэрэгцээтэй хүн хүчээр хангахын тулд зарцтай байхыг зөвшөөрч байжээ.

Түүнээс гадна богино хугацаанд амжуулах шаардлагатай зарим төрлийн ажлыг (хонь хяргах, эсгий хийх г.м.) бусдын хүчээр гүйцэтгүүлж тодорхой хэмжээний хөлс төлөх буюу хариу тус хүргэхийн аль аль хэлбэрийг ашиглах нь монгол малчин ардын аж төрөх ёсны нийтлэг шинж байв. Үүнийг хэлтийлгэн үзэж нийт олноороо зарц ажиллуулж байсан гэх буюу хөдөлмөрийн хоршоолол аль хэзээнээс байсан хэмээн үзэж болохгүй нь мэдээж.

Дээр өгүүлснээс үзэхэд Монголын төр засаг зарц нарын тухайд бодлогыг төрөөс мал сүргийн талаар явуулсан бодлоготой уялдуулж үзэхээс өөр аргагүй нь тодорхой байна. Нөгөө талаар улсын эдийн засгийн үндэс болсон мал сүргийг өсгөж олшруулахын тулд аж ахуйтны хувийн сонирхлыг дэмжих зайлшгүй шаардлагыг анхаарахын сацуу баян чинээлэг айл өрх зарц хэрэглэхийг зөвшөөрөхөөс өөр арга байгаагүй нь тодорхой байна.

Гэтэл зарцтай айл өрхийн тэргүүнийг хөрөнгө чинээнийх нь байдал, зан авирыг нь ч хайхралгүйгээр нүд үзүүрлэн үл бүтэх этгээд, мөлжигч феодал хэмээн хавчин хяхаж байсан явдал бол Монголын төрийн бодлогын алдаа байсан бөгөөд түүнээс өнөө үед сургамж авах ёстой. Жишээлбэл, 1924 онд батлагдсан БНМАУ-ын Үндсэн хуульд заасан “Ямагташгийг эрмэлзэж бусдыг зарж мөлжин амьдрагчид,

³⁵ Хууль, дүрэм, тогтоолын эмхэтгэл, УБ, 1932. №5, 213.

³⁶ БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль, УБ, 1941, 84.

ямагтбусдыг хөлслөн зарах ба хөрөнгө орлого зэргийн үржлээр амьдрагч жинхэнэ худалдааны ба мөнгө хүүлэгчид”³⁷ 1944 он хүртэл сонгогдох эрхгүй байв.

Ингэж зарцтай хүмүүсийг “мөлжин амьдрагчид” хэмээн үзэж элдвээр гадуурхах явдал 1924-1959 ондхөдөө аж ахуйг хоршооллож дуустал үргэлжилжээ. Үүний уршгаар өөрийн хүчээр маллаж хүч хүрэхгүй зарим өрх арц хэрэглэхээсээ цэрвэж малаа үрэн таран хийх нь ч цөөнгүй байсан ажээ. 1959 оны эцэс хүртэл Монголын хүн амын нэг хэсэг болж хүч хөдөлмөрөөрөө амь зууж байсан зарц нарын тухай хураангуй өгүүлэхэдийм буюу.

10. Малчдыг өмчгүй болгосон хоршоолол

1932 оны зунаас эхлэн ШЭБ-ыг хэрэгжүүлэх явцад Завхан, Сэлэнгэ зэрэг аймагт ганц нэг нөхөрлөл таралгүй үлдэж хүч хөдөлмөрөө хоршин тариалан эрхэлж, аян жин тээж ашиг олж байв. Иймээс төр засаг тэдний үйл ажиллагааг дэмжих зорилгоор 1932 онд “Ардын үйлдвэрлэлийн нэгдлийн дүрэм” баталсан юм. Уул дүрэмд хамтын аж ахуйг эрхлэхэд аж ахуй, санхүү, зохион байгуулалтын хувьд анхаарах зүйлийг тодорхойлон заажээ. Тэрхүү дүрэмд зааснаар АҮН-ийн гишүүнд элсэгчид элсэлтийн татвар 2᠓, хувь нийлүүлэх хөрөнгө 10᠓ төлөх болов. Харин АҮН-д элсэх хүн заавал сонгуулийн эрхтэй байхыг үндсэн болзол болгон заасан боловч 1934 оноос уул заалтыг харгалзахгүйгээр АҮН-д элсүүлэх болжээ.

АҮН-ийг төрөөс дэмжиж байсан боловч хувийн аж ахуйтнууд хамтын аж ахуйд итгээгүй зүүнтний үеийн коммуна шиг юм болно хэмээн болгоомжилсоор байв. Тиймээс ч албан ёсны мэдээгээр 1935 онд улсын бүртгэлд АҮН ердөө ганц байсан бол 1940 онд 91, 1941 онд 96, 1945 онд 99 байжээ³⁸. Ийнхүү 1941 оноос эхлэн арван хувийн аж ахуйтнууд ноос, мал, сүүг улсад албан журмаар бэлтгэх болсон ба хэрэв АҮН-д элссэн бол арай хөнгөлөлттэй байв. Иймээс 1941 оноос хойш ардын хувийн аж ахуйтнууд АҮН-д дуртай дургүй ч элсэхэд мал аж ахуйн зарим бүтээгдэхүүнийг улсад албан журмаар нийлүүлэх хууль шууд түлхэц болсон юм. Үүний нотолгоо ч бэлхэн байна. Тухайлбал, нэгдүгээрт малчид АҮН-д элсэхдээ заавал мал нийгэмчлэх болзлыг зөрчихгүйн тулд мал сүргийнхээ хамгийн тааруухан буюу эмгэгтэй, үр төлгүй, бие давжаа, ашиг шим сайнгүйг нь нэгдэлд өгч байжээ. Хоёрдугаарт, улсад заавал тушаах ноос, мал сүүний төлөвлөгөөг биелүүлэхгүй бол хуулийн хариуцлага хүлээдэг байлаа. Харин АҮН-ийн гишүүн өрхүүд улсад нийлүүлэх албан журмын бэлтгэл нь хувийн аж ахуйтнаас арай бага байсан юм. Иймээс хувийн аж ахуйтнууд АҮН-д элсэж улсын бэлтгэсэн зүйлээсээ бага боловч хөнгөлүүлэхийг гол болгож байжээ. Түүнээс бус хамтын аж ахуй хувийн аж ахуйгаас илүү давуу гэж ухаарсангүй зүйл огт байгаагүйг 1980-аад онд Ховд, Увс, Баян-Өлгий, Говь-Алтайгаар явж ахмад хүмүүстэй уулзахад зарим нь ний

³⁷ Балхаажав, Ц, *Улсын анхдугаар их хурал: БНМАУ-ын анхдугаар үндсэн хууль*, УБ, 1956, 36.

³⁸ *БНМАУ 50 жилд*, УБ, 1971, 43.

Монголын төр ба мал сүрэг (1921-1959)

нуугүй ярьж байсан нь үнэн бизээ. АҮН-ийг аж ахуй санхүүгийн хувьд дэмжиж хувийн аж ахуйтны сонирхлыг татахын тулд төрөөс цогц бодлого хэрэгжүүлж байв. Тухайлбал, 1953 оны 3-р сард АҮН-ийн тэргүүнийг сайчуудын улсын зөвлөлгөөн болж зарим сайн ажилтай гишүүдийг шагнаж урамшуулжээ. Бас АҮН-ийг Хөдөө аж ахуйн нэгдэл (ХААН) гэж нэрлэв. Шинэ дүрэм батлан ХААН-ийн гишүүн бүхэн жилд 75-аас доошгүй хөдөлмөр өдөр ажиллах болов. Мөн ХААН-үүдийн ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 1954 оноос эхлэн банкнаас мөнгө зээлүүлэх байв. Хувийн аж ахуйтнуудыг ХААН-д элсүүлэхийн тулд тэдний малаас хураах татварын хэмжээг ХААН-ийн гишүүдийнхээс харьцангуй дээгүүр тогтоож байлаа. Эдийн засгийн энэхүү албадлагаас зайлсхийхийн тулд хувийн аж ахуйтнууд ХААН-д элсэх нь түргэсчээ. Малаас хураах татварын хэмжээ 1953-55 онд хэрхэн өөрчлөгдсөнийг дор үзүүлье.

Хүснэгт 8. 1953-1955 онд Ардын хувийн аж ахуйтны малаас хурааж байсан татварын хэмжээ

Аж ахуйтны малын тоо	Нэг толгой малаас				
	Тэмээ	Үхэр	Адуу	Хонь	Ямаа
21 хүртэл	3	1	2	0,50	0,25
21-50	5	2	4	0,75	0,50
51-100	6	4	5	1,00	0,75
101-200	7	5	6	1,50	1,00
201-500	8	6	7	1,75	1,25
501 түүнээс олон	9	7	8	2,00	1,50

1954-1955 он

Аж ахуйтны малын тоо	Нэг толгой малаас хураах ₮				
	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
21-50	2,50	2,00	1,00	0,35	0,25
51-100	4,00	3,00	2,00	0,70	0,40
101-150	6,00	5,00	4,00	1,20	0,75
151-200	7,00	6,00	5,00	1,50	1,00
201-300	8,00	7,00	6,00	1,75	1,25
301-400	8,50	7,50	6,50	1,85	1,50
401-500	9,00	8,00	7,00	2,00	1,75
501-700	9,45	8,40	7,35	2,10	1,85
701-1000	9,90	8,80	7,70	2,20	1,90
1001 ба түүнээс олон	10,35	9,20	8,00	2,30	2,00

Сурвалж: Үнэн 1954-V-9, БНМАУ-ын Бага хурал, Засгийн газраас гаргасан хууль, дүрэм, тогтоолуудын эмхэтгэл 1950-1953, №2,6, УБ, 1955.

3. Лонжид

Хүснэгтээс үзэхэд, 1953 онд ардын хувийн аж ахуйтнуудыг ердөө 6 бүлэг болгож байсан бол 1954-55 онд 10 бүлэг болгож 21 хүртэл малтай өрхийг татвараас бүрмөсөн чөлөөлж 51-100 хүртэл малтай өрхийн татварыг бага зэрэг хөнгөлж бусад бүлгүүдийг ногдох татварын хэмжээг 24.1%-иар нэмжээ. 1953 оны хуулиар 501-ээс дээш малтай бүх өрх ижил хэмжээний татвар төлж байсан бол 1954-55 онд 401-ээс дээш толгой малтай өрхүүдийг таван бүлэг болгож 8.5-10.35₮-ийн татвар хураах болсон нь мал олонтой өрхийн төлөх татварын хэмжээг эрс нэмжээ. Хувийн аж ахуйтнууд үүнээс зайлсхийх зорилгоор нэг өрх хэдхэдэн өрх болсон байдаг. Гэвч 1954 оноос эхлэн хувийн аж ахуйтнууд нэгдэлд элсэхээс өөр гарцгүй болгож арга буюумалаа нийгэмчлэх болсон юм. Жишээлбэл, 1954 онд ардын аж ахуйтны 5.4% нь ХААН-д элссэн байсан нь 1957 онд 34.3% болжээ. Төр засаг хувийн аж ахуйтнуудыг аль болох богино хугацаанд хоршоолох шаардлагатай хэмээн үзсэн учир 1958 оны 3-р сард МАХН-ын 13-р их хурлаас тогтоол гаргаж ардын хувийн аж ахуйтныг сайн дурын зарчмыг үндэс болгож ойрын гурван жилээр хоршоолон нэгтгэхийг заав. Үүнээс хойш төр засаг зөвхөн эдийн засгийн албадлага буюу албан татвар, улсын албан журмын бэлтгэлийн хуулиар сүрдүүлсээр 1959 оны 11-р сард гэхэд хувийн аж ахуйтнуудын 99.3% нь ХААН-д элсчээ.

1945-1959 онд хоршоолох үйл явц хэрхэн үргэлжилснийг доорх хүснэгтээр үзүүлье.

Хүснэгт 9. Хоршоолох үйл явцын зарим үзүүлэлт

Он	Нэгдлийн тоо	Нэгдлийн гишүүдийн тоо	Ардын хувийн аж ахуйтны хэдэн %	Нийгэмчилсэн малын тоо	
				Хэдэн толгой	Улсын бүх малын хэдэн %
1945	99	-	-	27,9	0,1
1947	103	-	-	42,9	0,2
1952	165	-	-	280,5	1,2
1953	173	9788	4,5	420,8	1,8
1954	183	11445	5,4	979,5	4,4
1956	565	44119	22,7	3893,3	16,3
1957	678	66403	34,3	5223,6	22,4
1958	727	145900	75,0	7738,3	33,3
1959	389	193039	99,3	16882,6	70,6

Сурвалж: Ухуулагчийн лавлах бичиг, УБ, 1958, 89, Эдийн засгийн асуудлууд 1959 №1, БНМАУ-ын улс ардын аж ахуйн хөгжилт, Статистикийн эмхэтгэл, УБ, 1960, 31, 61, Үнэн 1960-II-7, 1961-I-31.

Нэхэж судлуштай зүйл гэвэл, 1958 оны 9-р сарын сүүлчээс 1959 оны 10-р сар хүртэлх хугацаанд хэд хэдэн аймагт нилээд олон нэгдэл байгуулагдсан боловч албан ёсны статистикт ороогүй байдаг. Тэдгээрийн нилээд нь ах дүү хамаатан саднаараа нийлж байгуулсан нэгдэл байсан гэдэг.

11. Сайн дурын зарчмаар бус хүчээр нэгдэлжүүлсэн нь

1958 оны хавар хуралдсан МАХН-ын 13-р их хурлаасгаргасан шийдвэрт ардын хувийн аж ахуйтныг ойрын гурван жилд сайн дурынх нь үндсэн дээр хоршооллон нэгтгэнэ гэж заасан юм. Энэ шийдвэрийг уншиж судалсан зарим хүн нэгдэлдэлсэхгүй байгаагийнхаа учрыг тайлбарлахдаа “САЙН ДУРЫНХНЬ ҮНДСЭН ДЭЭР” гэж нам,засаг заасан байна. Гэтэл нам,сумын дарга Та нар төрийн бодлогыг завхруулж байна хэмээн орон нутгийн удирдлагын шаардлагад хариу хэлсээр нэгдэлд элсээгүй гэдэг. Гэвч улсын бэлтгэл, албан татварын дарамтаар сүрдүүлж хувийн аж ахуйтныг хүчээр нэгдэлжүүлснийг эх түүхийн суурь бүтээлүүд,бүх шатны сурах бичгүүдэд нууж хаалгүй тод томруун бичих цаг аль хэдийнээ болжээ.

Хэдэн мянган жилийн турш үеэс үедуламжлан амь зуулгынхаа эх сурвалж болгож ирсэн мал сүргийг нь ганц зоос өгөхгүйгээр булааж авах гэсэн нам,төрийн түрэмгий санаархлыг олон хүн эсэргүүцэж байсан боловч тэдэнд дээшээ тэнгэр хол доошоо газар хатуу байлаа. Тиймээс 1958-59 онд зарим хүн нэгдэлдэлссэнээс амиа егүүтгэсэн нь дээр хэмээн хувь заяагаа шийдсэн байдаг. Зарим нь хэдгурван малаа тун хямд үнээр зарж борлуулаад хот суурин бараадаж хог цэвэрлэгч,сахиул манаач мэргэжил сонгожээ. Харин зарим нь халуун ам бүлийнхээ амьжиргааг залгуулж байх үүднээс ам бүлээ хэд хэд салгаж 4-5 өрх болж хэмжээ хязгаарт тааруулж хэдгурван малаа авч үлдсэн ажээ.Тодруулж хэлбэл ХААН-ийн хамгийн сүүлчийн дүрэмд зааснаар говийн бүсийн нэг өрхөд 75,хээр,хангайн бүсийн нэг өрхөд 50 малтай байхыг зөвшөөрч байсан учир зарим нутагт эхнэр нөхөр хоёр “салж” тус тусдаа өрх болох,эсвэл 16-гаас дээш настай охидхөвгүүдээ тусгай өрх хэмээн данслуулах тохиолдол газар бүхэнд байсан билээ.

Манай нам,төр засгийн удирдах ажилтны зарим нь хувийн аж ахуйтныг нэгдэлжүүлэхээс цэрвэж Зүүнтний үеийн хамтрал,нөхөрлөл,коммуна,артель шиг юм болчих бий дээ хэмээн болгоомжилж байжээ. Харин зарим нь харь хүмүүсийн зөвлөсний дагуу хувийн жижиг өмчтөнийг ямар ч аргаар болов нэгдэлжүүлж том аж ахуйтан болгочихвол Монгол Улсын мал сүрэг тариа будаа шиг үржиж өснө хэмээн дахин дахин донгодож байв. Үүнээс гадна Сахалт багшийн айлдсан ёсоор ойрмог хугацаанд мал сүргээ 200 сая хүргэх бүрэн боломжтой хэмээн яс махаараа итгэж хоёр дүнчүүр малтай болохын тулд нэгдэлжүүлэхээс өөр гарцгүй шүү дээ гэж 1940-1959 онд бүтэн 20 жил ухуулж сурталчилсаар байсан боловч алсын хараатай эгэл монголчууд түүнд ер хууртаагүй юм. Гэвч эцэст нь эдийн засгийн хүчирхийллээр хувийн аж ахуйтны 99 гаруй хувийг нэгдэлжүүлж дууссаны өвлөөс эхлээд мал сүргийн тоо толгой чамлахааргүй хурдацтай цөөрч хорогдох болсон юм. Өөрөөр хэлбэл хүлээж байсан үр дүн талаар өнгөрчээ. Үүний статистикийн албан ёсны мэдээнээс толиму Та. 1959 оны эцэст 23895.1 сая байсан мал 1962 оны

эцэст 23000.5 сая болж 894600-гаар буюу 3.75%-иар хорсон байдаг.³⁹ ХААН гучин гурван жил оршин тогтнох хугацаанд мал сүргийн өсөлт өр тогтворжсонгүй хөдөлгөөнийхний амь зуулга аж байдалд ч төдий л ахиц гарсангүй харин ч өмч эзэнгүйдэх, дундын хөрөнгийг үрэн таран хийх, завших байдал улам бүр газар авсан учир арга буюу таржээ. Үүнээс хойш мал сүрэг тогтвортой өссөөр 2012 оны эцсээр 40 сая гаруй малтай боллоо.

Дүгнэлт

Монголын төр 1921-1924 онд хүн амынхаа амь зуулгын үндсэн эх сурвалж мал сүргийн талаар тусгай бодлого боловсруулан хэрэгжүүлж байсан билээ. Гэтэл 1925-1928 онд ЗХУ-ын удирдагчид уул бодлогыг элдвээр буруутгаж хувийн өмчтнийг ялангуяа баян малчдыг дэмжих нь улс орны эрх ашигт туйлын сөрөг нөлөөтэй. Хувийн мал сүргийг эхлээд нийгэмчилж дундын өмч болго, дараа нь төрийн мэдэлд шилжүүл хэмээн шаардаж түүндээ байнга хяналт тавьсаар 1959 онд бүрэн хэрэгжүүлсэн үйл явцыг энэ өгүүлэлд тун хураангуй авч үзлээ.

Abstract: Between 1921 and 1924 Mongolian Government developed and implemented a specific state policy on livestock which was the main source of living for Mongolian people. However, during the period of 1925 and 1928 there was a tremendous amount of pressure from the Soviet Union leaders and they denounced the policy in all sorts. The Soviet leaders said that promoting private ownership would adversely affect the national interest of Mongolia and therefore it was necessary to nationalize and transfer the private livestock to cooperative ownership and, after that to seize them as state property. They constantly controlled and forced this objective upon Mongolian authorities and due to such pressure in 1959 the same was fulfilled. The implementation process of such event is briefly described in this article. I have mainly tried to use new sources which have not been circulated in historical research before.

³⁹ БНМАУ-ын Хөдөө аж ахуй 50 жилд. Статистийн эмхтгэл, I-р хэсэг, УБ, 1974, 50.